

**ДОРНОГОВЬ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022 оны 11 дүгээр сарын 18

Сайншанд

№	Бодлогын зорилго, зорилт	Арга хэмжээ	Төсөв /сая төгрөг/		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжилт
			Төсөвлөсөн	Гүйцэтгэл		Он	Түвшин	Он	Түвшин	
НЭГ. ҮНДСЭНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ										
Зорилго 1. Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.										
1	1.1. Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ	1.1.1. Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, стандарт шаардлагад нийцсэн орчин, соёл урлагийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулна.	16.1 тэр бум	2.0 тэр бум	Барилгын гүйцэтгэлийн хувь	2020	100%	2022	100%	Улсын төсвийн 16,7 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд суманд 700 хүний суудалтай Саран Хөхөө театрын барилга барих ажлыг "Болор-Аграмба" ХХК-аар гүйцэтгүүлэн, барилгын газар шороо, суурь, зоорины давхрын каркасан хийцийн угсралт бүрэн, тайзны хэсгийн багана, дам нуруу болон хөгжимчдийн хэсгийн дам нурууны угсралтын ажил хийгдсэн. Улсын төсөвт 2021 онд 1,0 тэрбум, 2022 онд 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд санхүүжилтийн хүрээнд төлөвлөсөн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100% биелсэн.
2		1.1.2. Орон нутгийн түүх соёлыг илэрхийлсэн бүтээл туурвих, соёлын биет болон биет бус оюуны үнэт өв, бүтээлийг олон		65.4 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Цахим технологид шилжсэн хувь	2020	2 40%	2022	4 100%	Хүүхэд бүр музейд үйл ажиллагааны хүрээнд алслагдсан сумдын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад музей үзэх боломжийг бүрдүүлж "Цахим музей" арга хэмжээг зохион байгуулан, Замын-Үүд, Алтанширээ, Айраг, Дэлгэрэх, Улаанбадрах зэрэг 5 сумын 400 сурагчийг хамруулсан. Байгаль орчин, шинжлэх ухаан, танин мэдэхүйн 256 төрлийн цахим сургалтад давхардсан тоогоор 12312 суралцагч, танхимын сургалтын үед байгалийн ухааны хичээлээр 15172 суралцагч хамрагдаж байгаль орчин, шинжлэх ухаан, танин

		нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлнэ.								<p>мэдэхүйн мэдлэгийг олгосон.</p> <p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/279 дүгээр захирамжаар “Язгуур алтан өв” соёлын биет бус өвийн аймгийн анхдугаар наадмыг 2022 оны 05 дугаар сард амжилттай зохион байгуулж, 7 ай савын хүрээнд 14 сумын 321 өвлөн уламжлагч оролцсноос нийт 31 өвлөн уламжлагчийг шалгаруулан шагнаж урамшуулсан ба “D media” агентлагтай хамтран шилдэг өвлөн уламжлагчдын өвийг цахим сан үүсгэн хадгалж, өвлүүлэн үлдээх зорилгоор ярилцлага, тоглолтын бичлэг бүхий нийт 8 нэвтрүүлэг, 14 сум тус бүрийн тоглолтын бичлэгээр цахим сан үүсгэсэн.</p> <p>“Язгуур алтан өв” соёлын биет бус өвийн аймгийн анхдугаар наадмыг ЕБ-ын сургууль, цэцэрлэгийн нийт 3000 гаруй хүүхэд, багачууд, 2000 гаруй иргэд, нийт 5000 гаруй хүнд сурталчлан танилцуулж, орон нутгийн телевизээр шууд дамжуулан, DTV болон байгууллагын пэйж хуудсанд байршуулсан бичлэгийг 10,000 хүнд хүргэсэн.</p>
3		1.1.3. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг хэвшүүлнэ.		1.0 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2020	2	2022	4	<p>Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 257-р тогтоолын хүрээнд хүн бүр удмаа мэдэж, угийн бичгийг хөтлөх үндэсний уламжлалыг хэвшүүлэх зан үйлийг сургах зорилго бүхий 69 удаагийн сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж 1767 гэр бүлийн 4707 иргэнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 30,2 хувиар буюу 1425 иргэнээр өссөн үзүүлэлттэй байна. “Угийн бичиг хөтлөх арга зүй” гарын авлагыг боловсруулан бэлтгэж малчин иргэдэд 150 ширхэгийг хүргэв. Угийн бичиг хөтөлдөг өрх 2020 онд 1335 байсан бол 2022 оны байдлаар 1577 өрх болж 242 өрхөөр өссөн.</p>
4	1.2. Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.	1.2.1. Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг		1,350 20,0	Зохион байгуулсан ажлын тоо Шинээр байгуулсан кабинетын тоо	2020	2 3	2022	20 2	<p>Монгол бичиг үндэсний хөтөлбөр-3"-ыг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. “Босоо бичиг бидний бахархал-2021” сайхан бичигтэн, уран бичигтэн иргэд, албан байгууллагыг шалгаруулах цахим уралдааныг зохион байгуулж, 44 сурагч, 132 иргэн, 34 байгууллага, нийт 1034 иргэнийг тус тус хамруулсан. Үндэсний бичиг үсгийн баярын өдрийг угтан "Монгол эх хэл бичиг-1000 онооны эзэн" цахим сорилго зохион байгуулж, бага ангийн 240 багш, цэцэрлэгийн 203 багш, 14 арга зүйч, элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 220 сурагчийг хамруулан, амжилт гаргасан багш сурагчдыг урамшуулсан. Насан</p>

		дээшлүүлнэ.								<p>туршийн боловсролын төвөөс Төрийн байгууллагын албан хаагч болон хувь иргэн 712 хүнд үндэсний бичгийн сургалтыг зохион байгуулах, нутгийн алдарт зохиолчдын бүтээл, яруу найргийг монгол бичиг рүү хөрвүүлэн цахимд байршуулах, төрийн албан хаагчид болон иргэдийн дунд "Цахим уншлага" арга хэмжээг зохион байгуулж дүгнэх, байгууллага бүр "Монгол бичгийн булан"-тай болох зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Монгол хэл уран зохиол, үндэсний бичгийн багш Э.Цэвэгсүрэн, Э.Хандсүрэн нарын хамтарсан "Хүмүүн бичиг" үзэсгэлэнг зохион байгуулан 100 гаруй хүнд, еөнхий боловсролын 21 сургууль "Үндэсний бичиг үсгийн баяр", "Эх хэлний өдөр", "Номын баяр" үйл ажиллагааг зохион байгуулж, Монгол хэлний тухай шинэ хуулийг сурталчлан, "Монгол бичгийн номын үзэсгэлэн", "Сайхан бичигтэн", "Тэргүүний уншигч"-ийг шалгаруулан, "Монголчуудын бичиг үсгийн дурсгал", "Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлье" зэрэг 20 гаруй үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 892 хүнийг хамруулсан.</p> <p>Насан туршийн боловсролын төв болон Айраг сумын ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн иргэдэд зориулсан үндэсний бичгийн танхимыг тус тус байгуулан, үндэсний бичгийн толь, сурах бичиг, компьютер, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүн гарын авлага болон 4 нэр төрлийн 28 ширхэг техник хэрэгсэл, 158 ширхэг сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, 205 ширхэг бага үнэтэй түргэн элэгдэх бараа бүтээгдэхүүн бүхий 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 121 иргэн тус кабинетээр үйлчлүүлсэн.</p>
--	--	-------------	--	--	--	--	--	--	--	--

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг хангана.

5	2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших	2.1.1. Сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулан,	0	0	СӨБ-ын хамрагдалтын хувь	2020	89.1 %	2022	97.6 %	Боловсрол шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/292, А/525 тушаалын дагуу танхим, цахим хосолсон хэлбэрээр хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулан, төрийн өмчийн 33, хувийн өмчийн 3, нийт 36 цэцэрлэгийн 159 бүлэгт 3655 хүүхдийг хамруулсан.
---	--	---	---	---	--------------------------	------	--------	------	--------	---

	боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ	хүртээмжийг нэмэгдүүлж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.								Нийт суралцагчдын 3266 буюу 89.3 хувь нь үндсэн, 389 буюу 10.6 хувь нь хувилбарт сургалтад хамруулснаас 317 буюу 81.5 хувь нь нүүдлийн бүлэгт, 72 буюу 18.5 хувийг нь явуулын багшийн сургалтад тус тус хамруулсан. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 87.6 хувь, 5 настай хүүхдийн хамран сургалт 94.2 хувь болж нэмэгдсэн.	
6		2.1.2. Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмж, сурлагын чанарт суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана.	55,0	2020	2021	4	5	1875	94	26	<p>Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан “Дэлхийн том хичээл-Тогтвортой хөгжил” улсын уралдаанд ЕБС-аас 20, СӨБ-оос 16 хичээл оролцож 5 багшийн хичээл улсын хэмжээнд шалгарч түгээн дэлгэрүүлэх туршлагын санд багтсан. Монгол улсад орчин цагийн боловсролын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтаж, Зүүн бүсийн цэцэрлэгүүдийн багш нарын дунд “Чадварлаг багш-2021” ур чадварын уралдаан “Багш-суралцахуйг хөтлөгч, Багш-сурахуйг дэмжигч” уриатайгаар 3 үе шаттайгаар 5 цэцэрлэгийн 30 багшийг хамруулан ЕБС, СӨБ-ын багш нарын дунд цахим хичээл ур чадварын уралдааныг 1052 багшийг оролцуулж 3 удаа, “Зорилгын хүч” арга хэмжээний арга зүйн зөвлөмж шалгаруулах уралдааныг 10 сургуулийн 20 багийн 100 багшийг хамруулан 1 удаа тус тус зохион байгуулсан.</p> <p>“Математик” сонины нэрэмжит олимпиад, олон Улсын Математикийн “Кенгуру” олимпиадад 21 сургуулийн 1-12 дугаар ангийн 128 суралцагч оролцож 1 дүгээр зэргийн диплом 12, 2 дугаар зэргийн диплом 8, 3 дугаар зэргийн диплом 14, нийт 34 суралцагч зэрэг хүртсэн. Цэцэрлэг, ЕБС-ийн багш удирдах ажилтны эрдэм шинжилгээний хурлыг Боловсролын хүрээлэнгээс 55 дахь удаагаа зохион байгуулж, Сайншанд сумын 3 дугаар сургуулийн “Монгол хэлний баг”-ийн илтгэл шалгарч “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт танхимын ба цахим хичээл” сэдвийн дор 3 сард болсон цахим хуралд амжилттай оролцсон. “Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт оны шилдэг илтгэлийн уралдааныг 21 сургууль, 36 цэцэрлэгийн хэмжээнд зохион байгуулсан ба 228 багийн 912 багш, ажлын байран дээр нь хөгжүүлэх зорилгоор 2 удаагийн илтгэл, 3 удаагийн олимпиад, 5 удаагийн ур чадварын уралдааныг зохион байгуулж давхардсан тоогоор 2115 багш тус тус хамрагдсан.</p>

									<p>"Алтан зул" арга хэмжээг цахимаар зохион байгуулж, "Алтан зул" наадмын шагналт Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийн Монгол хэлний багш Б.Амаржаргал, Математикийн багш Г.Батхишиг нарын туршлага, арга зүйг аймгийн багш нарт түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Багш дор мөргөмү" тусгай нэвтрүүлгийг бэлтгэн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан ард түмэнд хүргэснээс гадна элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан 2 багшийн арга зүйг 1875 багшид түгээн дэлгэрүүлэв.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/335 дугаар тушаалын дагуу "Боловсролын тэргүүний ажилтан"аар 24, "Жуух бичиг"-ээр 60 багш ажилтныг, аймгийн Засаг даргын жуух, өргөмжлөлөөр 42 багш ажилтныг тус тус шагнаж урамшуулсан. Орчин цагийн боловсролын салбарын 100 жилийн ойн медалийг хэвлүүлэхэд орон нутгийн төсвөөс 1.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 849 багш ажиллаж байгаагийн 11.2 хувь нь магистр, 76.4 хувь нь бакалавр, 12.4 хувь нь дипломын зэрэгтэй байна. Монгол Улсын боловсролын их сургуулийн сургалтын дараах магистрын сургалтын Боловсролын удирдлагын ангид 2, Засагт хан дээд сургуулийн сургуулийн өмнөх боловсролын магистрын эчнээ ангид 8, нийт 10 багшийг боловсролын зэрэг ахиулах магистрын сургалтад хамруулсан. Боловсролын салбарт 94 магистр зэрэгтэй багш, удирдах ажилтан ажиллаж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 15-аар нэмэгдсэн.</p> <p>2021-2022 оны хичээлийн жилд 99 оюутанд, 2022-2023 онд 15 оюутанд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн.</p>
7		2.1.3. Монголын түүх, хэл, соёл, ёс заншлаа мэддэг, эх орноороо бахархдаг төлөвшсөн ухаалаг иргэдийг бэлтгэнэ.	921	Хугагтын нутгаар Торгон хил сэдэвт үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн тоо	2020	400	2022	2500	<p>Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/556 дугаар захирамжийн дагуу "Хугагтын нутгаар-Торгон хил" арга хэмжээг жил бүр ерөнхий боловсролын 20 сургуулийн 6-9 дүгээр ангийн 5151 суралцагчдад экологийн хүмүүжил олгох, сумдын байгаль, түүхийн гайхамшигт газруудын соёлыг таниулах, эх орноороо бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалт</p>

										болон аяллын арга хэмжээг хослуулан зохион байгуулсан. Сайншанд сумын ерөнхий боловсролын сургуулийн 40 суралцагчийг Хамарын хийд, Хан Баянзүрх хайрхан, Шамбалын орноор аялуулж нутгийнхаа түүх соёлтой, Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн 21 суралцагч, багш нарын төлөөллийг Сулинхээрийн отрядын анги нэгтгэлтэй танилцуулан, "Алдрын танхим", Цэргийн ангийн зохион байгуулалт, зэвсэг техник, үзүүлэх тоглолт зэрэг үйл ажиллагаанд хамруулсан.
8		2.1.4. Боловсролын салбарт ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.		15,000,0	Шинээр баригдсан барилгын гүйцэтгэлийн хувь Их завсар хийгдсэн сургуулийн гүйцэтгэлийн хувь	2020		2022	2 сургууль	Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотор халаалт, цэвэр бохир усны шугамын засварын ажлыг орон нутгийн төсвийн 694.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Аббадон констракшн" ХХК гүйцэтгэж, УЖД-41/2021 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад 100%, Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын засварын ажлыг орон нутгийн төсвийн 65.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Эргэл хийц" ХХК гүйцэтгэн, УЖД-51/2021 дугаартай комиссын дүгнэлтээр хүлээн аван, ашиглалтад 100% тус тус оруулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн 7722.6 сая төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд сумын 6 дугаар багт 640 хүүхдийн сургуулийн барилга барих ажлыг "Болор-Аграмба" ХХК, улсын төсвийн 3.04 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 2 дугаар сургуулийн өргөтгөл 320 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлыг "Жинсийн-Орой" ХХК гүйцэтгэж, ашиглалтад энэ онд багтаан хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Улсын төсвийн 7,6 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Хатанбулаг суманд 320 хүүхдийн сургуулийн барилга барих ажлыг "Ньюконстракшн" ХХК-иар гүйцэтгүүлэн, газар шороо, суурь, 1, 2-р давхрын каркасан хийцийн угсралтын ажил, 3-р давхрын багана, дам нуруу, хучилт цутгах ажил бүрэн хийгдсэн. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40%-тай, 2022 онд батлагдсан 2,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүрээнд төлөвлөсөн ажлын хэрэгжилт 100 хувьтай байна.
9		2.1.5. Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" үйлчилгээг		70,0	Гал тогооны тоног төхөөрөмж сайжруулсан сургуулийн тоо	2020	3 4	2022	5 8	Боловсролын чанар хүртээмж, үйлчилгээний чанарыг сайжруулах, суралцагчдын эрүүл аюулгүй таатай орчинд сурч хүмүүжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар Эрдэнэ,

		бүрэн нэвтрүүлнэ.			Ундны усны шүүлтүүрээр хангагдсан сургуулийн тоо					<p>Сайншанд сумын 1 дүгээр сургуульд 16,7 сая төгрөг, Замын-Үүд сумын 1 дүгээр сургуульд 18,5 сая төгрөг, Хөвсгөл сумын сургуульд 17,2 сая төгрөг, Алтанширээ сумын сургуульд "Салхин парк" ХХК -аас 6,5 сая төгрөг, улсын төсвөөс 1,5 сая төгрөг буюу нийт 5 сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг 60,4 сая төгрөгөөр шинэчлэн сайжруулсан.</p> <p>Суралцагчдын эрүүл аюулгүй таатай орчинд сурч хүмүүжих боломжийг бүрдүүлэх зорилгоор Сайншанд сумын ерөнхий боловсролын 1, 3 дугаар сургууль, Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Алтанширээ, Айраг, Хөвсгөл, Эрдэнэ сумдын ерөнхий боловсролын сургуулиудад улсын төсвийн 5,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 ширхэг ундны усны шүүлтүүрийг шинээр авч байршуулсан.</p> <p>Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль өөрийн төсвөөс 770,0 мянган төгрөг, Үлэмж тэнгэр сургууль 650,0 мянган төгрөгөөр ундны усны шүүлтүүрийг сайжруулсан. Нийт 8 сургууль 9 ширхэг 7,0 сая төгрөгийн ундны усны шүүлтүүрийг шинээр авч, сургуулийн 1, 2 давхрын корпуст байрлуулан суралцагчдыг цэвэр ус уух, эрүүл орчинд сурч, боловсрох нөхцөлөөр ханган ажилласан.</p> <p>Хатанбулаг сумын сургуулийн дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 25,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Чиглэл" ХХК-иар гүйцэтгүүлж, гэрээний дагуу 19 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.</p> <p>Даланжаргалан, Дэлгэрэх, Өргөн, Замын-Үүд сумын сургуулиудын дотуур байрыг нийт 42,3 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан нь өмнөх оноос 3-р өссөн.</p>
10		2.1.6. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамир, соёлын танхимыг		101,0	Тоног төхөөрөмжөөр хангагдсан сургуулийн тоо	2020	2	2022	7	<p>Боловсролын чанар хүртээмж, үйлчилгээний чанарыг сайжруулах, суралцагчдын эрүүл аюулгүй, таатай орчинд сурч хүмүүжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Мандах, Сайхандулаан сумын цэцэрлэгт 12,2 сая төгрөгийн хөгжмийн зэмсэг, Улаанбадрах сумын цэцэрлэгийн урлаг танхимд 8,0 сая, Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн урлаг танхимд 10,0 сая, Сайхандулаан, Дэлгэрэх, Сайншанд сумын 1 дүгээр сургуульд тус тус биеийн тамирын тоног төхөөрөмжид</p>

		стандартын тоног төхөөрөмжөөр хангаж, соёл, бие бялдрын өв тэгш хөгжилтэй иргэдийг бэлтгэнэ.								<p>23,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн.</p> <p>Аймгийн 3 цэцэрлэг, 1 сургуулийн дуу хөгжим, урлаг танхимыг 30,2 сая төгрөг, 3 сургуулийн биеийн тамирын заалыг 70,8 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. Нийт боловсролын 7 байгууллагыг 101.0 сая төгрөгийн урлаг, биеийн тамирын тоног төхөөрөмжөөр хангаж суралцагчдын суралцах таатай орчныг бүрдүүлэн ажилласан.</p> <p>Сайншанд сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн урлагийн танхимд 10,0 сая төгрөгийн хөгжмийн тоног төхөөрөмж, 2-р сургуульд 8,7 сая төгрөгийн 30 морин хуур, 5-р сургуульд 4,8 сая төгрөгийн 15 морин хуур хөгжмийг 2022 онд тус тус нийлүүлсэн. Сайншанд сумын 3-р сургууль 3,0 сая төгрөгийн хөгжим, Хатанбулаг сумын сургууль 8,2 сая төгрөгийн хөгжим, Алтанширээ сумын хүүхдийн цэцэрлэгийн урлагийн танхимд нийт 7,2 сая төгрөгийн хөгжим, техник хэрэгсэл худалдан авч сургалтын орчныг сайжрууллаа. Энэ онд 5 сургууль, цэцэрлэгийн биеийн тамирын залны тохижилт, хэрэгсэл болон урлагийн танхимын хөгжим, техник хэрэгслийг үе шаттайгаар нэмэгдүүлж, нийт 43,6 сая төгрөгийг зарцуулан, хүүхдийн хөгжлийг дэмжин ажилласан нь өмнөх оноос 66,6%-аар өссөн.</p>
11		2.1.7. Цахим сургалтыг хөгжүүлэхэд багш нарын оролцоог дэмжиж, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.		720,0	Нийлүүлсэн компьютерийн тоо	2020	50	2022	330	<p>Боловсролын чанар хүртээмж, үйлчилгээний чанарыг сайжруулах, багшийг ажлын байран дээр нь хөгжүүлэх зорилгоор БСШУЯ-наас Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 2, Замын-Үүд сумын 1 дүгээр сургуульд 1, Сайншанд сумын 2 дугаар цэцэрлэгт 1, Замын-Үүд сумын 7 дугаар цэцэрлэгт 1, нийт 5 компьютер, 12 цэцэрлэг, 5 сургуульд сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, гал тогооны хэрэгсэл, компьютер, хөгжим, тавилга, зөөлөн эдлэл зэрэг 328 нэр төрлийн 1629 ширхэг 143,3 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангаж суралцагчдын суралцах таатай орчинг бүрдүүлсэн. Сайншанд сумын ерөнхий боловсролын 1, 2, 5 дугаар сургууль, Сайхандулаан, Замын-Үүд сумын 1 дүгээр сургуульд улсын төсвийн 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11 зөөврийн компьютер худалдан авч, 70 компьютерын хурдыг хүчин чадал өндөртэй хард, рамаар шинэчлэн сайжруулсан.</p> <p>Хатанбулаг сумын ерөнхий боловсролын сургуульд орон</p>

										<p>нутгийн сангийн 37,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Мэдээллийн технологийн кабинет”-ыг байгуулсан. “Доншен газрын тос” ХХК, “Норико” ХХК-иас 20 сургуульд 105 ш зөөврийн компьютерийн дэмжлэг үзүүллээ.</p> <p>БШУС-ын багцаас 21 сургууль, 36 цэцэрлэгт 368,3 сая төгрөгийн 125 зөөврийн компьютероор хангасан. Боловсролын салбарын 56 байгууллагад нийт 330 компьютерын дэмжлэг үзүүлж, 84 компьютерын хурд хүчин чадлыг сайжруулж, бусад тоног төхөөрөмжөөр хангасан.</p>
12		<p>2.1.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийг стандартад нийцсэн орц гарц, ариун цэврийн байгууламжтай болгож, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангана.</p>	30,0	<p>Сайжруулсан орчин нөхцөлийн гүйцэтгэлийн хувь</p> <p>ХБХ-ийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтын хувь</p>	2020	3	119	2022	3	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын судалгаанд бүртгэлтэй 272 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас 141 хүүхэд боловсролын үйлчилгээнд хамруулсан.</p> <p>Тусгай хэрэгцээт хүүхдийг сургах, хөгжих боломжийг ханган “ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТАНХИМ”-ыг Сайншанд сумын 1 дүгээр сургууль дээр байгуулж тоног төхөөрөмж 9.6 сая төгрөг, ном, сурах бичиг 2.5 сая төгрөг, тоглоом, хэрэглэгдэхүүн-2.3 сая төгрөг, сэргээн заслын хэрэгслүүд 16.0 сая төгрөгийн өртөг бүхий танхимын тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн хүлээж авч, нийт 30.4 сая төгрөгийн хөрөнгөөр боломжийг бүрдүүллээ.</p> <p>Сайншанд сумын 11 дүгээр цэцэрлэгийн Тусгай хэрэгцээт боловсролын “Тэмүүлэл” бүлгийн 2 багш ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхэд зориулсан арга зүйн зөвлөгөө, зөвлөмж бүхий 9 цахим уулзалт сургалтыг хийн, тусгай боловсролын багшийг томилон ажиллуулсан.</p> <p>“Тэгш тусгал” ТББ-аас “Монголын сонсголгүй иргэдийн хэлний адилслыг бэхжүүлэх” төслийн хүрээнд дохионы хэлний судалгааг хийн, хэлгүй дүлий 8 хүн хамруулж, сургалтын хөтөлбөр боловсруулах, дохионы хэлний online толь бичиг бүтээж байршуулах, дохионы хэлний хэлмэрч бэлтгэх, хэрэглээнд нэвтрүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажилладаг 20 төрийн байгууллагын 24 албан хаагчдад 4 удаагийн Дохионы хэлний сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролд 17, Ерөнхий боловсролын сургуульд 105, Насан туршийн боловсролын төвд 19, нийт 141 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцан, таатай</p>

										орчинг бүрдүүлэхэд 30.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 24 албан хаагч дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй болсон.
13		2.1.9. Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийг политехникийн коллеж болгох ажлыг эхлүүлж, их, дээд сургуулиудын үйл ажиллагааг дэмжинэ.			Политехникийн коллежийн тоо Мэргэжлийн тоо	2020	- 19	2022	1 19	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2020 оны 11 сард Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэлд орж, Хөдөлмөр нийгмийн хамгаалалын сайдын 2021 оны А/68 тоот тушаалаар Дорноговь Политехник коллеж болон өргөжиж 19 мэргэжлээр элсэлт аван үйл ажиллагаагаа явуулсан. Төмөр замын замчин, Барилгын засал чимэглэл, Гагнуурчин зэрэг мэргэжлүүдээр аймгийн Политехникийн коллежид 2020-2021 оны хичээлийн жилд 462 суралцагч, 2022-2023 оны хичээлийн жилд 337 суралцагч шинээр элсэж, 2,5 жилийн сургалтыг 7 мэргэжлээр 204, 1 жилийн сургалтыг 9 мэргэжлээр нийт 16 мэргэжлээр 159 суралцагч тус тус төгсөн уул уурхай, барилга, төмөр замын салбарын мэргэжилтэй боловсон хүчнээр бэлтгэгдсэн.
14		2.1.10. Насан туршийн боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэж, суралцах орчин бүрдүүлнэ.	28,0		Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	2020	210 1500 0	2022	228 5992	Иргэдэд насан туршийн боловсрол олгох чиглэлээр амьдрах ухааны 41 сургалтад 1251, гэр бүлийн боловсрол олгох 37 сургалтад 1102, иргэний боловсрол олгох 35 сургалтад 735, ёс суртахууны боловсрол олгох 35 сургалтад 909, гоо зүйн боловсрол олгох 36 сургалтад 607, шинжлэх ухаан, мэдээллийн технологийн 18 сургалтад 392, тогтвортой хөгжлийн боловсрол олгох 25 сургалтад 555, хэлний сургалтад 95, санхүүгийн боловсрол олгох цахим сургалтад 441, нийт цахим болон танхим хосолсон 228 удаагийн сургалтад 5992 иргэнийг хамруулсан. Насан туршийн боловсролын төвийн орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор монгол бичгийн кабинетыг байгуулж 10,0 сая төгрөгний 8 нэр төрлийн 90 ширхэг тоног төхөөрөмж, сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүн, Иргэдийн танхимыг азийн хөгжлийн банкны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх" төслийн хүрээнд 18,9 сая төгрөгний 18 нэр төрлийн 45 ширхэг сургалтын тоног төхөөрөмжөөр хангасан.
15		2.1.11. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн ач	2,0		Эрдэм шинжилгээний ажлын тоо	2020	-	2021	1	"Medical Science VI International conference" олон улсын эрдэм шинжилгээний хурал, "Эрдмийн чуулган 68 салбар хуралдаан" -ыг цахим хэлбэрээр зохион байгуулсан арга

		холбогдол бүхий бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжинэ.							хэмжээнд Америк, Япон, Нидерланд зэрэг орнуудаас 7 зочин илтгэгч, АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбарын сургуулийн багш, судлаачид оролцсон. "Чадварлаг оюутан-2021" Анагаахын сургуулиудын оюутнуудын дунд эрдэм шинжилгээний хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж 46 судлаач оюутан оролцож анагаах ухаан, сувилахуй, нийгмийн эрүүл мэндийн, цахим технологийн талаар судалгааны бүтээлүүдээ хэлэлцүүлсэн. Японы Шизуока мужийн Анагаах ухааны сургууль, Токиогийн София их сургууль, АНУ-ын болон Тайландын Сувилахуйн сургуулиудтай хамтран уулзалт, семинарыг 3 удаа зохион байгуулж багш, оюутнууд туршлагаа хуваалцсан. Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийг тоон үзүүлэлтээр авч үзвэл дотоодод хэвлэгдсэн өгүүллийн тоо 13, олон улсын хуралд 18 илтгэл тавигдсан. Орон нутагтаа ургадаг цулжир, хулангийн ундаа, загасгал зэрэг эмийн ургамлын найрлагаар "Очир увдис" элэг хамгаалах, дархлаа сэргээх цайг бүтээх туршилтын ажлаа хийж, патент авахаар материалаа хүргүүлсэн.
16	2.2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээн ий технологи йг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж	2.2.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэн бүр эрт илрүүлэгийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх	12.8	1029.4	ЭМСС-д хамрагдсан хүний тоо, үзлэгт хамрагдсан хүний тоо Төлөвлөгөө хэрэгжилтийн хувь Идэвхтэй тандалтанд хамрагдсан хүний тоо	2020	2022	5460 0 4500 88% 2650 0	Эрүүл, идэвхтэй амьдрал арга хэмжээний 2021-2024 онд хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 59 ажил хийхээр батлуулж төлөвлөгөөний хэрэгжилт 87% байна. Эрүүл мэндийн 1180 удаагийн сургалт сурталчилгаанд 38390 хүн хамрагдаж 73 төрлийн 8964 гарын авлага тарааж, цахимд 82 төрлийн мэдээллийг байршуулж 39657 хандалт авсан нь өмнөх оноос 856 хандалтаар өсч иргэдийн мэдлэг, хандлага нэмэгдэв. Аймгийн ГХУСАЗС3-тай хамтран сурагчдын дунд "Архигүй ирээдүй" эссэ бичлэг, "Хүчирхийлэлгүй гэр бүл" гар зургийн, ЭМГ, ГБХЗХГ, Сайншанд сумын ЗДТГ-тай хамтран 16-аас дээш насныхны дунд "АРХИ ТАМХИНААС ТАТГАЛЗАЖ ГАНГАРЪЯ" уран илтгэлийн уралдаан, Дэлхийн тамхигүй өдрийг "Тамхинаас гарахаар шийд" уриан дор тус тус зохион байгуулж 120 хүүхэд оролцож, 17 ЭМБ 10215 иргэдэд тамхины хор уршиг, тамхинаас гарахыг уриалав. Зонхилон тохиолдох ХБӨ-ний 5 эрт илрүүлэг үзлэгт 73694 хүнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 11752 хүнээр нэмэгдэж, ажил олгогчдын албан хаагчдаа сэргийлэх үзлэгт хамруулах хандлага нэмэгдэж нийт 18 байгууллага

үйлчилгээ ний чанар, хүртээмж ийг сайжруулн а.	арга хэмжээг хэрэгжүүлнэ.									<p>1983 албан хаагчаа багцын үзлэг шинжилгээнд хамруулсан.</p> <p>Аймгийн Засаг даргын 2021 оны А/257 захирамжаар Халдварт болон халдварт бус өвчний явуулын цогц үзлэгт 32.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж, шүдний эмчийн явуулын үзлэгийг урд бүсийн 8 суманд зохион байгуулж нийт 1334 хүн хамрагдсаны 1052 /78.8%/ нь хүүхэд, цэргийн насны залуус 44 /3.2%/ ба шүдний өвчлөлтэй 1160 хүний 2024 шүдэнд эмчилгээ хийж, 651 /56.1%/ хүнийг эрүүлжүүлсэн нь өмнөх оноос хүний тоо 347-р, 14.6%-иар буурсан. Глобаль сангийн дэмжлэгтэй Эрүүл мэндийн цогц үзлэгийг бүх сумдад зохион байгуулж 3000 хүнийг хамруулж, 20.0 сая төгрөгний дэмжлэг авсан.</p> <p>Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх хөтөлбөрийг 90,0%-тай хэрэгжүүлж, 2689 сургалт сурталчилгаанд 132695 хүн хамрагдаж, иргэдийн мэдлэг хандлага, идэвх оролцоо нэмэгдсэн.</p> <p>Товлолын дархлаажуулалтын хамралт 97,0%-д хүрч 114,3 сая төгрөгийн 3 хөлдөөгч, 21 хөргөгч нийлүүлэгдснээр хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хангалт 100%-д хүрч, шинээр 15 сувилагчийг дархлаажуулалтын мэргэжил олгох сургалтанд хамруулснаар анхан шатны байгууллагууд 100% 2 сувилагчтай болов.</p> <p>Зорилтот бүлгийн хүн амын коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын хамралт 1-р тунд 96,1%, 2-р тунд 92.4%, 3-р тунд 30,1% байна.</p> <p>Сүрьеэгийн сорьц тээвэрлэлт сайруулах төслийн хүрээнд 13 сумаас 126 хүний цэрний сорьцыг тээвэрлэж, 12 шинэ сүрьеэг илрүүлж, эмчилгээ хяналтанд авлаа. БЗДХ-ын идэвхтэй тандалтанд 2415 хүнийг хамруулж 222 БЗДХ-ыг шинээр илрүүлэн, 100% эрүүлжүүлснээр 10000 хүн амд ногдох БЗДХ 31.5 болж өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар буурч, төрөлхийн тэмбүү бүртгэгдээгүй.</p> <p>Коронавируст халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээг эрчимжүүлж, 6 сургалтанд 320 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан чадавхжуулж, нийт 820 ор дэлгэж, Сайншанд, Замын үүд суманд нэг цэгийн үйлчилгээг нээж, төрийн өмчийн ЭМБ-д 134429 түргэвчилсэн, 113188 ПГУ шинжилгээг хийж, нийт 19046 халдварыг илрүүлж, 87,4%/16651/-нь эдгэрч, 0,3%/59/нь нас барж, 2210 хүн</p>
---	------------------------------	--	--	--	--	--	--	--	--	--

										эмчлүүлсэн.
17	2.2.2. Орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулан, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бодлогоор дэмжин, орон нутагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.	915.8		Лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	2020	52	2022	60	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад орон нутгийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар 3 нэр төрлийн 6 ширхэг 29.3 сая төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж анхан шатанд лабораторийн тоног төхөөрөмжийн хангалт 58%-д, өрх, сумын ЭМТ-үүд биохими, шээсний хагас анализатортой болж, эмч нарыг ЭХО, ЗЦБ хийж, дүгнэлт гаргах чадвар олгох сургалтанд үе шаттайгаар хамруулж, лабораторийн 13 нэр төрлийн түргэн оношлуураар хангаж, 4 төрлийн шинжилгээний сорьц тээвэрлэлтийг хийж, 7 сум мобайл технологийг нэвтрүүлсэн.</p> <p>Арьсны болон элэгний В вирусын цахим оношилгоог бүх эмнэлгүүдэд нэвтрүүлж, явуулын үзлэг, оношилгоог хийдэг болсноор “Хаалга барих” үйлчилгээний хүрээ өртгөжиж, 2020 оноос Ковид-19 халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуурын шинжилгээ, ПГУ шинжилгээний сорьц цуглуулах техникт сургаж анхан шатны эрүүл мэндийн төвүүд 100% гүйцэтгэж, лабораторийн зарим шинжилгээг орон нутагтаа хийдэг болсноор иргэд сумандаа тусламж авах боломж нэмэгдэж, 13а маягтаар дээд шатлалд оношилгоо шинжилгээ хийх иргэдийн тоо 8,6%иар буурсан.</p> <p>Коронавирусын цар тахлын үеийн эмнэлгийн бэлэн байдлыг хангах зорилгоор амьсгалын аппарат, эрчимт эмчилгээ яаралтай тусламж, лабораторийн аппаратуудыг шинэчилж хангалтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлж буй 2 Нэгдсэн эмнэлэгт амьсгалын аппарат 24, хүчилтөрөгч өтгөрүүлэгч 28, өвчтөний хяналтын монитор 15 ширхэг шинээр нэмэгдэж нийтдээ улс, орон нутаг, олон улсын байгууллага, ААН, компанийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар 10,0 тэрбум төгрөгийн 129 ширхэг тоног төхөөрөмж нэмэгдэж тоног төхөөрөмжийн хангалт дунджаар 83.2% /аймгийн Нэгдсэн эмнэлэг-92.8%, Замын-Үүд Нэгдсэн эмнэлэг - 73.7%/ -д хүрч, короновируст халдварын эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдэж, маш хүнд өвчтөнг эмчлэх боломжтой болсон.</p>	
18	2.2.3. “Цахим Монгол” арга хэмжээний	31.5	154.1	Цахим санд байгаа мэдээллийн тоо	2020	220000	2022	2732 96	Аймгийн болон Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгүүдийн e.health программын баазад 273296 үйлчлүүлэгчийн мэдээлэл хадгалагдаж байна. Эрүүл мэндийн	

		хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгал, эм зүйн тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ.			Мобайл технологи нэвтрүүлсэн АШЭМБ-ын тоо,		3		3	байгууллагуудад 2021 онд 109 компьютер шинээр авч интернэтийн хурдыг нэмэгдүүлсэн. Коронавирусын цар тахал болсонтой холбогдуулан Eguul.mn программыг нэвтрүүлж COVID-19-халдварыг илрүүлэх оношийг баталгаажуулах ПГУ болон түргэвчилсэн шилжилгээний мэдээллийг оруулж, сан үүсгэн, 2 компьютер, ПОС машин 15 ширхэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гар утас, bluetooth принтер ашиглаж, ПГУ шинжилгээний сорьцны мэдээллийг уншуулж улмаар шинжилгээний хариу иргэнд цахимаар хүргэсэн. Эрүүл мэндийн байгууллагууд COVID-19 дархлаажуулалтын Vls.health.gov.mn программыг, burtgel.moh.mn, tandalt.gov.mn зэрэг программуудыг ашигладаг болж ор, хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэглэл, ариутгалын бодис, хэвтэн эмчлүүлэгчдийн мэдээллийг өдөр бүр мэдээлж мэдээллийн шуурхай бодит байдлыг ханган ажиллахын зэрэгцээ эдгэрсэн иргэд QR код, эмнэлгийн магадлагаа, вакцины мэдээллийг цахимаар авах боломжтой болсон. Коронавируст халдварын тандалт судалгааг эрчимжүүлж, google form-оор асуумж судалгааг авч, бүртгэгдсэн 19046 халдварын тохиолдол түүний ойр, дамын хавьтал 47184 хүнийг шуурхай илрүүлж, голомтыг тогтоож, шуурхай хүмий нөхцлийг бүрдүүллээ. Мандах, Айраг, Эрдэнэ, Улаанбадрах сумдууд ЭМЯ, ОНХС-ийн 54,8 сая төгрөгийн, Алтанширээ, Сайхандулаан, Хөвсгөл сумдууд ОНХС-ийн 46,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мобайл технологийн тоног төхөөрөмжүүдтэй болж, 18 эмч мэргэжилтнийг багаар нь орон нутгийн сургалтанд хамруулан чадавжуулсан. Анхан шатны эмнэлгүүдэд мобайл технологи нэвтэрч, өмнөх оны түвшнээс 23%-иар нэмэгдсэн.
19		2.2.4. Эрүүл мэндийн ажилтны хөгжил, нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийг	1230.8	2020	Сургалтад хамрагдсан хүний тоо	2022	3432	3420	Ковидын цар тахлын улмаас гадаадын сургалт хойшлогдож, төгсөлтийн дараах мэргэжил олгох сургалтад нийт 24 эмч, мэргэжилтэн, цахим болон танхимын сургалтад давхардсан 2105, эрүүл мэндийн байгууллагуудын дотоодын сургалтад давхардсан тоогоор 1291 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, нийт 3420 хүний мэдлэг чадварыг дээшлүүллээ.	

		сайжруулж, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлж, өндөр хөгжилтэй улс орон болон дотоодын сургалтад хамруулж тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжоор хангана.			Хүний нөөцийн хангалт ын хувь		90		90	<p>Эрүүл мэндийн байгууллагуудын сул орон тооны мэдээллийг нэгтгэн цахим хуудас 6, facebook 8 зарыг байршуулж ил тод байдлыг ханган ажилласнаар нийт 15 эрүүл мэндийн байгууллагад 110 эмч эмнэлгийн мэргэжилтэн ажилтанг ажлын байраар хангав. Анхан шатны ЭМБ-уудын хүний нөөцийн хангалт 87.3%, лавлагаа шатлалын эмнэлгүүдийн хангалт 95,3%, салбарын хэмжээнд хүний нөөцийн хангалт дунджаар 91.3% байна.</p> <p>Сумдын эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж байгаа 8 эмч мэргэжилтнийг төрийн албан хаагчийн орон сууцанд үнэ төлбөргүй амьдруулах, мөнгөн дэмжлэг үзүүлэх, өвлийн идэшээр хангах, бүлээрээ ажиллаж байгаа эмч нарыг малжуулах төсөлд хамруулах зэрэг дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Цар тахлын үед улаан бүсэд ажиллаж байгаа эмч мэргэжилтнүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах, дархлааг дэмжих, ар гэрийг дэмжих, халдвараас сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлж, ЭМЯ-аас салбарын 787 ажилтанд тус бүрд 1,4 сая төгрөгийн дэмжлэгийг, Дорноговь аймгаас сонгогдсон УИХ-ын 2 гишүүн 790 ажилтанд тус бүр 100,0 мянган төгрөгний дэмжлэг, 300 ажилтанд дархлаа дэмжих багц өгч ажиллах урмыг сэргээсэн.</p>
20		2.2.5. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	2665.9 сая	2665,9	Гүйцэтгэлийн хувь	2020	0	2022	90	<p>Халдвартын эмнэлэг шинээр барих ажлыг "Төгс-Өнөд" ХХК, Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн барилгын барилгын газар шороо, суурийн ажил бүрэн хийгдэн 2022 онд ашиглалтад хүлээн авсан.</p> <p>Аймгийн Эрүүл мэндийн газрын гадна фасад, дотор халаалтын шугамын засварын ажлын гүйцэтгэл 100%, Замын-Үүд сумын хуучин Нэгдсэн эмнэлгийн 2 давхар барилгын их засварын ажил 100% хийгдсэн.</p> <p>Инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон Хатанбулаг, Алтанширээ, Дэлгэрэх, Даланжаргалан сумдын эрүүл мэндийн төвийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Чандмань-Илч" ХХК хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.</p>

21	2.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой есөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	2.3.1. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлнэ.			Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь Гүйцэтгэлийн хувь Эцэг эхийн зөвлөлтэй байгууллагын тоо	2020	-	2022	100% 90% 73 байгууллага	Аймгийн Засаг даргын 2021 оны А/309 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийг боловсруулан аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 53-р тогтоолоор батлуулсан. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг 13 сумын 33 эцэг эхийн зөвлөл, аймгийн төвд 35, шинээр Замын-Үүд суманд 5 цэцэрлэг, нийт 73 байгууллага, аж ахуйн нэгж дэргэдээ эцэг эхийн зөвлөл ажиллуулж, хүүхэд хамгааллын бодлогыг ханган ажиллаж байна. Эцэг эхийн зөвлөлийн ажиллах чиг үүргийн талаар 4 удаагийн цахим сургалт, 1 удаагийн танхимын сургалт, мөн 5 удаагийн чиглэлийг албан бичгээр хүргүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. "Өнөөдрийн оролцоо, маргаашийн хөгжил" уриан дор аймгийн хүүхдийн нэгдсэн Х чуулган, Монголын скаутын холбооны 2022 цугларалт, "Авах гээхийн ухаан" лекц, "Нандин" үндэсний чуулган, "Одоо бидний цаг үе, бидний ирээдүй" аймгийн хүүхдийн зөвлөгөөн, "Өсвөрийн парламент-2022" хөтөлбөрт зэрэг 17 төрлийн хүүхдийн хөгжил оролцоог дэмжсэн зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтад нийт 8450 хүүхдийг оролцуулсан. Мөн аймгийн Засаг даргын А/249 дүгээр захирамжаар сар бүрийн эхний 7 хоногийн Лхагва гарагийг "Хүүхдээ сонсох өдөр" болгож сум, агентлаг, төрийн байгууллагууд хуваарийн дагуу хүүхдийн дуу хоолой, санал бодлыг сонсож, хүүхдүүдээс гарсан саналыг нэгтгэн үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрч тогтмолжсон.
22		2.3.2. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах болон гэр бүлийн орчин нөхцөлийг сайжруулна.			Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	2020	21 3700 0	2022	23 3800 0	Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр "Хүүхэд эрхэм хэрэглэгч", "Гэрээсээ гэрэлтэе", "Хэрсүү гурвалжин", "Хайр нэмэх, хүчирхийлэл хасах" зэрэг нэгдсэн арга хэмжээгээр 26 төрөл, ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Олон улсын гэр бүлийн өдөр, Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдөр, Хүүхдийн эрхийг хамгаалах ОУ-ын өдөр зэрэг тэмдэглэлт өдрөөр "Эмэгтэйчүүд бидний эрх", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, "Өсвөр насныхны сэтгэл зүйн тулгамдсан асуудал" зэрэг 21 төрөл нийт 47 төрлийн урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 11355 иргэнийг хамруулсан.

									<p>Зорилтот бүлгийн иргэд, гэр бүлүүдэд гэр бүлийн боловсрол олгох, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 12 хосод гэрлэлтийн баталгаа гардуулах, өөрсдийн хүсэл эрмэлзлээр амьдралаа залгуулж яваа зорилтот бүлгийн 3 гэр бүлийг оролцуулсан 3 удаагийн ТВ нэвтрүүлэг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 10 иргэнд зан үйлд нөлөөлөх 3 удаагийн сургалтыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.</p> <p>Хүүхдийн эрх, хамгааллын тухай хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн үнэ цэнэ 8 төрлийн гарын авлагыг зорилтот бүлгийн 195 өрхийн 401 иргэнд, хүүхэд багачуудад зориулсан “Аюулгүйн 10 дүрэм” бяцхан номыг 593 хүүхдэд тараасан.</p> <p>Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг 31 байгууллага мөрдөж, 6 байгууллага шинээр эцэг эхийн зөвлөл байгуулан, аймгийн хэмжээнд нийт 79 аж ахуйн нэгж, байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс ажилтан, албан хаагчдынхаа гэр бүлд чиглэсэн гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа хандлага, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зэрэг соён гэгээрүүлэх 15 төрлийн нөлөөллийн арга хэмжээнд 963 албан хаагчийг гэр бүлийн гишүүдийн амт, “Болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр 118 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан сургалт зохион байгуулж, 15 төрийн байгууллагын 400 албан хаагч, 279 асран хамгаалагчдад “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт 36 удаагийн танхимын сургалтаар хүүхдийн хүмүүжил төлөвшлийн чиглэлээр нөлөөллийн ажлуудыг хийж хэрэгжүүлсэн</p>	
23		2.3.3. Нийгмийн харилцаан дахь залуучуудын хөгжил оролцоог сайжруулж, бүтээлч санал санаачилгыг дэмжинэ.			Дэмжсэн саналын тоо	2020	3	2022	5	<p>Залуучуудын хөгжил оролцоо, санал санаачилгыг дэмжих зорилгоор 14 суманд залуучуудын элчийг томилж, залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулсан. Залуучуудын хөгжил, оролцоо манлайллыг хангах зорилгоор 2 удаагийн цахим чуулган, "Хайр бэлэглэе" хандивын аян, "Эртэч залуу" нөлөөллийн аян, "Хүүхдийн ертөнцөд өнгө нэмье" арга хэмжээ, Монгол ёс, өв уламжлалыг сурталчлан таниулах "Дээлээрээ гоёё" "Ментор-100" арга хэмжээ зэрэг залуусаас гарсан 7 шинэ санаачилга нь нийгэмд чиглэсэн сайн дурын ажил үйлчилгээ болсон.</p> <p>"Хайр бэлэглэе" хандивын аян, "Эртэч залуу" зэрэг</p>

										<p>нөлөөллийн арга хэмжээнд 100 орчим залуус нэгдэж түүх соёлоороо бахархах, эрүүл зан үйл, дадалд суралцах, хүүхэд, багачуудын сайн үйлсийн төлөө арга хэмжээг зохион байгуулж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Хүүхдийн тасаг”-т 5 ширхэг утлагын аппарат болон 320,0 мянган төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хөвсгөл сумын залуучуудаас "Хүүхдийн ертөнцөд өнгө нэмье" арга хэмжээг санаачлан сумынхаа ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны өрөө бүрийг номын сантай болгож, дотуур байранд амьдарч байгаа 55 хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчныг бүрдүүлсэн. "Ментор-100" арга хэмжээний хүрээнд амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 100 өрхийн амьдралыг сайжруулах олон талт нөлөөллийн ажлыг 100 ментор байгууллага хэрэгжүүлэн ажиллав.</p>
24		2.3.4. Хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэн хяналт тавьж, хүүхэд, гэр бүлд үзүүлэх үйлчилгээг сайжруулна.		10,0 ОНТ УТ 34130, 0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	2020	15 1500 0	2021	17 1600 0	<p>Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн хүрээнд бүх нийтийн гэр бүлийн боловсрол, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг эзэмшүүлэх зорилгоор эцэг эх, асран хамгаалагчдын хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар 2 төрлийн нөлөөллийн арга хэмжээ, 2 удаагийн цуврал сургалтыг 1286 иргэнд танхимын хэлбэрээр, 4914 иргэнд тараах материалаар дамжуулан 5925 иргэнд цахим нөлөөллийн ажлыг хүргэсэн.</p> <p>Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 25 хамтарсан багийн нарийн бичигт 34,1 сая төгрөгийн үнэ бүхий таблетын дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Аймгийн ГХУСАЗСЗ-өөс “Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх нь” сэдэвт бичил төслийн уралдааныг зарлаж, 5 суманд тус бүр 2,0 сая, нийт 10,0 сая төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлсэн.</p> <p>Сайншанд, Өргөн, Мандах, Алтанширээ зэрэг 8 сум "Жаргалтай гэр бүл", "Гэр бүлийн өдөрлөг" зэрэг гэр бүлийг дэмжсэн зөвлөгөөнийг хийж, мэргэжлийн лектор, сэтгэл зүйчдийг урьж оролцуулсан, Мандах сумын хамтарсан баг “Дэвжээ” тэмцээн зохион байгуулсан, аймгийн “Эцэг эхийн зөвлөгөөн”-ийг 12 сард зохион байгуулахаар төлөвлөсөн зэрэг нь эцэг эхийн хараа хяналтыг сайжруулах, хүүхдийн</p>

										хүмүүжилд эцэг эх, гэр бүлийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчныг бүрдүүлэх зэрэгт ач холбогдолтой үйл ажиллагаа болсон.
25	2.4. Эрүүл баталгаат орчныг бий болгоно.	2.4.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлэн, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.	2.0	2.0	Тухайн жилд шилэн хяналтын системд хяналт шалгалт хийжээр батлагдсан объектын тоо	2020	250	2022	226	<p>Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 250 объектод хяналт шалгалт хийжээр батлагдсанаас Коронавируст “Ковид-19” цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг нийт 226 объектод хийж гүйцэтгэл 90.4 хувьтай байна. Үүнээс Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын удирдамж болон иргэд, аж ахуйн нэгжээс ирсэн гомдол мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 98 объектод хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд улсын байцаагчийн албан шаардлага 126-г хүргүүлж, албан шаардлагын хэрэгжилт 68 хувьтай байна.</p> <p>Мөн COVID-19 цар тахлаас шалтгаалан хяналт шалгалт хийжээр төлөвлөсөн зарим аж ахуй, нэгжийн үйл ажиллагаа зогссон нь төлөвлөгөөт хяналт шалгалтын хэрэгжилтэд нөлөөлсөн. Мэргэжлийн хяналтын байгууллага нь хяналт шалгалтыг ил тод нээлттэй хийх үүднээс Шилэн хяналтын системд хяналт шалгалт хийх объектуудын мэдээлэл болон хяналт шалгалт хийсэн объектуудын эрсдэлийг их бага хэмжээгээр үнэлж эрсдэлийг тооцон ажилласан.</p>
26		2.4.2. Хот, суурин газруудад үерийн ус зайлуулах сувагчиллыг нэмэгдүүлнэ.	0	0	Сувагчлалын урт	2020	160	2022	210	<p>Айраг, Даланжаргалан, Сайншанд сумдуудад хот суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийг ерөнхий хот төлөвлөлтөд тусгахаар сумын хот төлөвлөлтийн зургийг гүйцэтгэгч компанид санал хүргүүлсэн. Алтанширээ, Дэлгэрэх, Улаанбадрах, Хатанбулаг сумдад хэрэгжүүлэх шаардлагагүй буюу үерт автахгүй газрын бүтэцтэй. Хөвсгөл, Эрдэнэ сумдуудад хэрэгжүүлэх боломжгүй гэж дүгнэсэн. Замын-Үүд суманд "Борхойн зам ХХК"-иас нийгмийн хариуцлагын хүрээнд 50 метр шуудууг төв талбайн зогсоолд борооны ус зайлуулах хоолойг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Сайншанд суманд Орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж бүр үерийн усны хамгаалалттай барилга байгууламж, ус зайлуулах шугам, авто замын доогуурх ус гүйлгэх шугамын хэвийн найдвартай байдлыг хангах, шар усны үерээс урьдчилан сэргийлэх, системийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах талаар 149 байгууллага аж</p>

										ахуйн нэгжид заавар зөвлөмж, албан тоот өгч, 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор үерийн хамгаалалтын далан 11, ус зайлуулах хоолой бүхий 8 газрын нийт 14,3 тонн хогийг цэвэрлэн хогийн цэгт асгуулан системийн найдвартай ажиллагааг хангасан.
27	2.5. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээн Д суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ.	2.5.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.		980,0	Төлөвлөгөөний хэрэгжилт	2020	100%	2022	100%	<p>Аймаг, сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны болон жилийн ажлын төлөвлөгөөг 5 зорилт 19 арга хэмжээтэй батлан, "Хямралыг урьдчилан харж бэлтгэлтэйгээр даван туулья-ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлнэ" уриан дор Ковид-19 цар тахлын дэглэмтэй холбоотойгоор сарын аяныг цахимаар зохион байгуулсан. Орон нутгийн DTV телевизтэй хамтран сарын аяны нээлт болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний талаар "Онцлох сэдэв" нэвтрүүлгийг 2 удаа бэлтгэн олон нийтэд хүргэсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын албан тоотоор 28 агентлаг, аж ахуйн нэгж байгууллага, 14 сумдын ХАБЭА-н зөвлөлийн дарга нарт 10 заалт бүхий чиглэл хүргүүлэн, "Хөдөлмөрийн харилцаанд хамтын гэрээ, хэлэлцээрийн гүйцэтгэх үүрэг, хэрэгжилт, Хөдөлмөрийн аюулгүй байдлын зохицуулалт", "ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чадавхийг бэхжүүлэх", "ХАБЭА-н удирдлагын тогтолцоо, MNS ISO 45001:2018 стандартын талаарх ойлголт, чадамжийг гүнзгийрүүлэх, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад стандартыг нэвтрүүлж эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх", "ХАБЭА-н нэн тэргүүнд тулгамдаж байгаа асуудлууд", "Нэн тэргүүнд ХАБЭА-2021" зэрэг цахим хурал, сургалт, уралдаан, хяналт, шалгалт, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэх 9 нэр төрлийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 500 гаруй иргэдийг хамруулан, орон нутгийн төсвөөс 980,0 мянган төгрөг зарцуулж, хэрэгжилтийг 90%-тай ханган ажилласан.</p>
28		2.5.2. Орон нутгийн бүтээн байгуулалттай уялдуулан эрэлт			Зуучлагдсан ажлын байрны тоо	2020	1088,	2022	1124	Аймгийн хэмжээнд байнгын 99, улирлын 7, түр 200, нийт 306 шинэ ажлын байрыг бүртгэснээс 123 нь орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний салбарын шинэ ажлын байр байна. Нийт 556

		хэрэгцээнд нийцүүлэн шинэ ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тогтмол нэмэгдүүлнэ.			Шинэ ажлын байрны тоо		747		783	иргэнийг ажлын байранд зуучлан ажилласнаас орон нутгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинээр бий болсон үйлдвэр, үйлчилгээний салбарын шинэ ажлын байранд 118 иргэнийг зуучилсан. Үүнээс 75 иргэн байнгын, 43 иргэн түр болон улирлын шинэ ажлын байранд орсон. “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөл”-д 18-34 насны сүүлийн 3 сар ажил хөдөлмөр эрхлээгүй, их дээд сургууль болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцдаггүй, ажилтай орлоготой болж ирээдүйгээ өөрчлөх хүсэлтэй 103 залуу сургалтад хамрагдаж, 54 оролцогч дадлагат гарч байнгын ажлын байранд 8, өөрөө өөртөө ажлын байр бий болгосон 2, шинээр мэргэжил сонгон суралцаж буй 6 оролцогч 2021 онд бүртгэгдэж байсан бол ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө өгөх үйлчилгээ, мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх сургалт, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 409-өөс доош оноотой нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай орлого багатай болон эмзэг бүлгийн өрхийн 290 иргэнийг хамруулж чадавхжуулсан. Үүнээс 214 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлан ажилласан. Коронавируст ковид-19 цар тахлаас шалтгаалан эдийн засаг хумигдаж, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа зогсонги байгаатай холбоотой шинэ ажлын байр, ажлын байрны захиалга буурсан.
29		2.5.3. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэлийн нэгдсэн сантай болно.			Мэдээллийн сангийн тоо	-	-	-	-	2021 онд 21 нэр төрлийн үйлчилгээ, 2022 онд 38 нэр төрлийн үйлчилгээ нэмэгдэж нийт нийгмийн халамжийн 64 нэр төрлийн үйлчилгээний хүсэлтийг цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. Дээрх үйлчилгээнд хамрагдах хүсэлт 2021 онд 3162 иргэн, 2022 онд 4639 иргэн хамрагдах хүсэлт гаргасныг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн. E-mongolia системд 4 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг оруулсан ба нийт үйлчилгээний 88,8 хувийг цахимжуулсан. Нийгмийн халамжийн 72 нэр төрлийн үйлчилгээний 64 нэр төрлийг цахимд шилжүүлсэн.

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

30	3.1. Нийгмийн даатгалын шинэчлэлийг хэрэгжүүлж, нийгмийн халамжийг оновчтой болгоно.	3.1.1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж ил тод болгон, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөнө.			Төлөвлөгөөний хэрэгжилт	2020	100%	2021	100%	<p>Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч "Нийгмийн даатгал" гар утасны аппликейшн, "www.daatguulagch.ndaatgal.mn" цахим хуудасны хөгжүүлэлтийг сайжруулж шаардлагатай мэдээллээ QR кодоор баталгаажуулж хэвлэх, цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэлийн насжилт өндөртэй өртэй байгууллагуудын авлагыг барагдуулах талаар журамд заасны дагуу шат дараалсан арга хэмжээ авч ажиллан, өр барагдуулахаар 9 байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлж, 13 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж 36 байгууллагын дутуу төлсөн шимтгэлийн барагдуулахаар Улсын байцаагчийн акт тогтоон төлбөрийг бүрэн барагдуулсан. Зөрчлийн хуулийн дагуу 3 байгууллагад 6,0 сая төгрөгийн шийтгэлийг ногдуулсан.</p> <p>Тэтгэврийн даатгалын сан 31,3 тэрбум төгрөг орлого төвлөрч төлөвлөгөөнөөс 98,4 хувиар биелсэн Тэтгэмжийн даатгалын сан 3,2 тэрбум төгрөг төвлөрч 103 хувиар биелсэн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан 3,2 тэрбум 100 хувиар биелсэн ажилгүйдлийн даатгалын санд 649,6 сая төгрөг 95,8 хувиар биелсэн. Нийт 17932 иргэнд 58,4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгосон. 2022 оны Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 100% биелүүлсэн.</p>
31		3.1.2. "Цахим нийгмийн даатгал" арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын үйл ажиллагааг үе шаттайгаар бүхэлд нь цахимжуулж,			үйлчилгээний тоо	2020	5	2022	7	<p>Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 246, А/245 дугаар хамтарсан тушаалаар Нийгмийн даатгалын анхан шатны маягуудыг цахимжуулахаар шийдвэрлэсэн. Нийгмийн даатгалын дэвтэр, тэтгэврийн дэвтэр, сайн дурын даатгалын гэрээ, ажил олгогчийн тодорхойлолт, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тодорхойлолт гэсэн 5 үйлчилгээ 2021 онд, "Цахим нийгмийн даатгал" арга хэмжээний хүрээнд 7 нэр төрлийн үйлчилгээг төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн системээр дамжуулан, нийгмийн даатгалын цахим дэвтрийг 456 иргэнд, тэтгэврийн цахим дэвтрийг 321 тэтгэвэр авагч, ажилгүйдлийн тэтгэмж 36</p>

		иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй болгоно.								хүсэлт, хөдөлмөрийн чадвар алдалтын эмнэлгийн хуудас, жирэмсэн болон амаржсаны эмнэлгийн хуудас нийт 1321, ажил олгогчийн тодорхойлолт 744-г олгох зэрэг үйлчилгээг цахимаар 2022 онд хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.
32		3.1.3. Нийгмийн халамжийн болон нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ил тод чирэгдэлгүй болгоно.	6700,0		Гүйцэтгэлээрээ	2020	-	2022	124	<p>Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 297 өрх үйлчилгээ авч байна. Алтанширээ, Мандах, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл гэсэн 5 суманд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрх байхгүй гэсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 15343 өрх байгаа бөгөөд доод түвшний 1428, харьцангуй бага хэрэглээтэй 3231, дундаж түвшний 7356, дунджаас дээгүүр 2724, илүү өндөр хэрэглээтэй 604 өрх байгааг тогтоосон. Үүнээс өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд бүртгэлтэй доод түвшний 1428 өрхөөс нөхцөл байдлын үнэлгээ хийж амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн 154 өрхийн 292 том хүн, 397 хүүхдэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нийгмийн халамжийн сангаас өссөн дүнгээр 140,5 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Өмнөх оны мөн үеэс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн тоо 149 өрхөөр буурч, халамжийн бусад үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 296 иргэнээр өссөн. Нийгмийн халамжийн үйлчилгээг 21505 иргэнд үзүүлж халамжийн сангаас 9.1 тэрбум төгрөгийг олгосон.</p>
33	3.2. Өрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцүүлэн орон сууцжуулах бодлогын хэрэгжилтийг хангана.	3.2.1 Иргэдийн худалдан авах чадварт нийцсэн, стандартын шаардлага хангасан орон сууцны төсөл хэрэгжүүлэх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.	ОНХС-222.3 сая.төг ОНТ-192.0 сая. төг	ОНХС-222.3 сая.төг ОНТ-192.0 сая. төг	Ашиглалтад орсон орон сууц, айлын тоо	2020	111	2022	300	Сайншанд сумын 3 дугаар багт үйлчилгээтэй 20 айлын орон сууцны барилгыг "ТОБЭМ" ХХК, 30 айлын орон сууцны барилгыг "Саруул талын өргөө" ХХК, Замын-Үүд суманд 25 айлын орон сууцыг Тулга констракшн ХХК 2021 онд ашиглалтад шинээр оруулсан. Мөн Даланжаргалан суманд хуучин дотуур байрыг төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц болгон засварласан. Айраг суманд 37 айлын орон сууцны барилгыг "Элит конкрет" ХХК, Сайншанд сумын 2-р багт 70 айлын орон сууцны барилгыг "Саруул талын өргөө" ХХК, Өргөн суманд "Монцемент билдинг материалс" ХХК-ийн ажилчдын 65 айлын орон сууцны барилгыг "Нар-Урт" ХХК, МГТБҮ-ийн хотхоны 4-р байр буюу 40 айлын орон сууцны барилгыг "Хангайн бигэр" ХХК, Улаанбадрах суманд

										төрийн албан хаагчийн 8 айлын орон сууцны барилгыг "Баянбогд-Өргөө" ХХК, Даланжаргалан суманд МАК ХХК-ийн хөрөнгө оруулалтаар төрийн албан хаагчийн 8 айлын орон сууцны барилгуудыг 2022 онд тус тус барьж ашиглалтад оруулсан. Нийтдээ 311 орон сууцыг ашиглалтад оруулсан.
34		3.2.2. Барилгын үндсэн нэр төрлийн материалын орон нутгийн эрдэс, түүхий эдийг ашиглан дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар бага өртөгтэй орон сууцаар хангах бодлогыг дэмжин ажиллана.	-	-	Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ	2020	1	2022	1	Замын-Үүд, Эрдэнэ сумын нутгийг хамарсан 26.3 га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын 2021/001А тоот тусгай зөвшөөрлийг Гантулгатрөйд ХХК-д олгож, Мандах наран-5 орон сууцны хорооллын 384 айлын орон сууцны барилгад бетон зуурмагийг зах зээлийн үнээс 35 хувиар бага буюу 1 м ³ зуурмагийг 123.5 мянган төгрөгөөр 9205 м ³ бетон зуурмаг нийлүүлсэн.
35		3.2.3. Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, стандартын шаардлага хангасан материалаар барилгын ажлыг гүйцэтгүүлнэ.	-	-	Сорьцын тоо	2020	541	2022	1000	Төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар орон нутаг барьж буй олон нийтийн зориулалттай барилга байгууламжийн ажилд хэрэглэгдэж буй барилгын материал, түүхий эдэд лабораторийн хяналтыг хэрэгжүүлснээр газар дээр нь шалгаж, чанарын шаардлага хангахгүй барилгын материал, түүхий эдийг хэрэглүүлэхгүй байх, чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлсоны үндсэн дээр хэрэглүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах, гүйцэтгэгч компани, барилгын материал нийлүүлэгчдэд тавих шаардлагыг нэмэгдүүлсэн. Тайлант онд нийт 34 ААН-ийн 1252 ширхэг дээжийг хүлээн авч сорилт шинжилгээ хийн, сорилтын үр дүнг гаргаж тайланг хүлээлгэн өгсөн. Нийт материалыг дотор нь задалвал: Бетон сорьц – 1202, тоосго – 20, хөөсөн полистрол хавтан- 16, элс – 7, дайрга- 1, хөнгөн бетон – 3, явган замын хавтан – 3ш байна.
36	3.3. Хөдөлмөр эрхлэлт,	3.3.1. Бичил бизнесийг дэмжих орчинг		60,0 сая	Хамрагдсан иргэдийн тоо	2020	Гүйцэтгэлээр	2021	Гүйцэтгэлээр	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж,

	бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	бүрдүүлнэ.								<p>гарааны бизнесийг дэмжих СТАРТ-АП арга хэмжээний сургалтыг “Хөгжлийн шийдэл” ТББ-ын дэргэдэх сургалтын төвтэй хамтран зохион байгуулж, сургалтад 23 залуучуудыг хамруулан чадавжуулж 1 иргэнд 10,0 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Монгол Улсад залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Бизнес эрхлэгч залуу арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн 1 иргэнд 4,0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлгүй дэмжлэг олгосон. Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 75 иргэнд танхимын сургалт, 1265 иргэнд цахим сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.</p> <p>Засгийн газраас хэрэгжүүлсэн “Оролцоо” төслийн хүрээнд сүүлийн 3 сарын хугацаанд ажил хөдөлмөр эрхлээгүй, зорилтот бүлгийн 243 залуучууд бүртгүүлснээс 176 залуучууд ярилцлагад орж 103 залуучууд УБ хотноо нэгдсэн сургалтад хамрагдаж, дадалагад нийт 54 оролцогч гарч 46 оролцогч дадлагаа бүрэн дуусгасан. Үүнээс 6 оролцогч байнгын ажлын байранд зуучлагдан 2 оролцогч өөрөө өөртөө ажлын байр бий болгосон.</p> <p>Малжуулах төслөөр 35 хүртэлх насны 10 малчин өрхийг хамруулж 46,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p>
37		3.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.	7,3 тэрбум	1,0 тэрбум 64,7 сая	Гүйцэтгэлийн хувь	2020	-	2022	100%	<p>Улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр Сайншанд суманд 60 ортой ахмадын сувиллын барилга барих ажлыг "Элит Конкрет " ХХК гүйцэтгэж, 2021 онд батлагдсан 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн хүрээнд барилгын газар шорооны ажил болон А, В, D блокын 1,2-р давхарын багана, дам нуруу, хучилтын бетон цутгалт, E блокын 1-р давхарын кракасан хийцийн бетон цутгалтын ажил, мөн гадна цахилгаан хангамжийн 10 кВ-ын 1.2 км агаарын шугам, 250 кВа хүчин чадалтай КТПН угсрах ажлыг 100% хийж гүйцэтгэсэн.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбар зөвлөлийн төлөвлөгөөг батлан төлөвлөгөөний хэрэгжилтийг 80%-тай гүйцэтгэн ажилласан.</p> <p>Ахмад настны хөгжил хамгааллын чиглэлээр 14 сумын</p>

										<p>ахмадын салбар хороотой хамтран 134 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, 19417 ахмад настныг хамруулан нийт 64.7 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Хүн ам, түүний дотор хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэгдсэн нийт 168 төрлийн арга хэмжээг зохион байгуулж, 88,5 сая төгрөгийг зарцуулснаар хүүхдэд ээлтэй 9 шийдвэр батлагдаж, 25000 гаруй иргэдэд мэдээлэл үйл ажиллагаа хүрч иргэдийн мэдлэг ойлголт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах, төрийн үйлчилгээ авахад эерэг үр дүн гарсан.</p>
38		3.3.3. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.		60,0 сая	Төсөл хөтөлбөрт хамрагдсан залуучуудын тоо	2020	24	2022	Гүйцэтгэлээр	<p>Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр тайлант хугацааны байдлаар 381 иргэн үйлчлүүлж, үүнээс 12 иргэнийг модуль сургалтад хамруулсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд "Эмэгтэйчүүдийн entrepreneurship ур чадварыг дээшлүүлэх, тэдний бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлэх"-д туслах зорилгоор "Эмэгтэйчүүдэд зориулсан цахим сургалт", "Миний мэргэжил-Миний сонголт", "Залуусаа сонсох өдөр", "Залуустай ярилцъя" зэрэг 8 сургалт, 4 төрлийн уулзалт арга хэмжээг танхимын болон цахимаар зохион байгуулж нийт 379 иргэнийг хамруулж, цахим орчинд 9125 хүний хандалт авсан.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж, гарааны бизнесийг дэмжих СТАРТ-АП арга хэмжээний сургалтыг "Хөгжлийн шийдэл" ТББ-ын дэргэдэх сургалтын төвтэй хамтран зохион байгуулж, сургалтад 23 залуучуудыг хамруулан чадавхжуулж 1 иргэнд 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Бизнес эрхлэгч залуу арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн 1 иргэнд 4,0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлгүй дэмжлэг, малжуулах төслөөр 35 хүртэлх насны 10 малчин өрхийг хамруулж 46,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p>
39	3.4. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаа	3.4.1. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр,		38.7 сая	Барилгын гүйцэтгэлийн хувь	2020	100%	2024	100% 3	<p>Өсвөр үе, залуучуудын Ази тивийн аварга шалгаруулах Боксын тэмцээнээс спортын мастер Ж.Баяр-Отгон дасгалжуулагчтай, Ө.Төгөлдөр залуучуудын 71 кг-ийн жинд тулалдаж шагналт 5-р байрт орсон бол Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн оюутан Ч.Отгонтуяа нь ОХУ-ын</p>

	с урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжт эй үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан бүрдүүлнэ.	хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ.			аварга шалгаруулах тэмцээн, уралдааны тоо		1/10			<p>Уфа хотод Чөлөөт бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилтай оролцсон.</p> <p>Өсвөр үе, залуучуудын шигшээ багийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь дэмжих журам"-ыг батлан, тив, дэлхий, улсын хэмжээнд аймаг, орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөн, медаль хүртсэн 28 тамирчин, бэлтгэл сургуулийг ханган оролцуулсан 4 дасгалжуулагчдыг 2021 онд нийт 3,0 сая төгрөгөөр урамшуулсан.</p> <p>"Хүүхэд хөгжил-2022" зорилтот жилийн хүрээнд өсвөр үеийн зүүн бүсийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн, Монголын бүх ард түмний спортын 15-р наадмын зүүн бүсийн сагсан бөмбөгийн тэмцээн, "Dornogovi open-2022" жюү жицүгийн нээлттэй тэмцээн, холимог насны боксчдын аварга шалгаруулах олон хотын нээлттэй тэмцээн, залуучуудын улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг 30 жилийн дараа амжилттай зохион байгуулж, тус томоохон тэмцээнүүдэд нийт 147 багийн 2000 гаруй тамирчдыг оролцуулсан.</p> <p>Улс, бүс, аймгийн чанартай 32 тэмцээн, уралдаан зохион байгуулан, улсын чанартай тэмцээн, наадмаас 53, бүсийн тэмцээнээс 122, аймгийн тэмцээнээс 370, нийт 545 медаль хүртсэн амжилт 2022 онд үзүүлсэн нь медалийн тоо, чанар 2021 оноос 100%-аар өссөн.</p> <p>Спортын арга хэмжээ болон тамирчдын амжилтыг ахиулахад зориулж орон нутгийн төсвөөс 80,0 сая, байгууллагын төсвөөс 66,0 сая, нийт 146,0 сая төгрөгийг зарцуулсан.</p>
40		3.4.2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбай, барилгын хүртээмжийг нэмэгдүүлнэ.		196,4 сая	Шинээр байгуулсан спортын талбайн тоо	2020	5	2024	3	<p>Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж зорилгоор Айраг сум ОНХС-ийн 61.0 сая төгрөгийн санхүүжилтээр 2 тоглоомын талбай шинээр байгуулж, чийрэгжүүлэх тоног төхөөрөмж, Алтанширээ сум 59,0 сая төгрөгийн ОНХС-ийн санхүүжилтээр сагсны талбай, Иххэт сум "Монгол соёл-Монгол хүмүүн" төслийн 7.9 сая төгрөгийн хөрөнгөөр 6 нэр төрлийн спортын хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй болж биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>Сайншанд суманд Хаан банкны санхүүжилтээр 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулагдан ашиглалтад орсон.</p> <p>Сайншанд, Замын-Үүд суманд стандартад нийцсэн хөл</p>

										бөмбөгийн болон граундгольфын талбай байгуулах, Эрдэнэ суманд соёл спортын цогцолбор шинээр барих ажлын зураг төсөв хийгдсэн боловч, төсвийн хэмнэлтийн хуулийн хүрээнд санхүүгийн асуудал шийдвэрлэгдээгүй, хүлээгдсэн.
41		3.4.3. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	8.0 сая	8.3 сая	Хичээллэгсдийн тоо	2020	4782	2024	7000	<p>Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр "Эрүүл мэндийн цахим гүйлт-2021" арга хэмжээ, "Алхангаа ярилцъя" 7 хоногийн аян, "Дасгал хөдөлгөөн хийцгээе" сарын аян, Цахим гүйлтийн дэлхийн аварга шалгаруулах "Vitality Running World Cup" тэмцээн, "Цахим гимнастрада" зэрэг биеийн тамирын арга хэмжээг 12 төрлөөр зохион байгуулсан. Хийн дасгалын аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2 насны ангиллаар 12 багийн 120 тамирчид оролцож шилдгүүдээ тодрууллаа. Уг арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 360 аж ахуй нэгж, албан байгууллага, иргэдээс 8000 орчим хүнийг хамруулсан бөгөөд нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоо өмнөх оноос 59.7%-аар нэмэгдсэн.</p> <p>Ерөнхий сайдын санаачилгаар "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяныг улсын хэмжээнд 2022 оны 2 дугаар сарын 16-наас 6 дугаар сарын 1-ний хооронд зохион байгуулан, Биеийн тамир, спортын улсын хороо "Монголын Гимнастикийн холбоо", "Үнэгүй Фитнес" төрийн бус байгууллага хамтран орон даяар шууд дамжуулсан өглөөний дасгалд 14 сумын 80 аж ахуй нэгж, байгууллагын давхардсан тоогоор 13730 иргэнийг хамруулсан ба идэвх санаачилгатай оролцсон 5 сум, 5 аж ахуй нэгж, байгууллага, 5 иргэнийг шалгаруулж, урамшуулсан. Энэ арга хэмжээ нь иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх, идэвхжүүлэх нөлөөллийн ажил болсон ба 8 сумын 20 аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагч, иргэд нийт 600 гаруй хүн тогтмол дасгал, хөдөлгөөн хийж хэвшүүлсэн.</p> <p>2022 онд нийтийн биеийн тамир, спортоор давхардсан тоогоор 15000 гаруй хүн хичээллэсэн нь 2021 оноос 10000 хүнээр өссөн үзүүлэлттэй байна.</p>
42		3.4.4. Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар,		30.4	Олон улс, улс, аймгийн тэмцээнээс авсан медалийн тоо	2020	10	2024	115	<p>"Дорноговь бага олимп-2021" спортын наадам 2021 оны 11 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд сагсан бөмбөг, волейбол, шатар, даам, ширээний теннис, дартс гэсэн 6 төрлөөр 14 сум, Сайншанд сумын 8 баг, Замын-үүд сумын 2 багийн 926 тамирчин хурд, хүч авхаалж самбаагаа сорин</p>

		амжилтыг дээшлүүлнэ.								<p>өрсөлдлөө. Тэмцээний нийлбэр дүнгээр Замын-Үүд сум тэргүүн байрт шалгарч алтан медаль цомын эзэд болж дэд байранд Сайншанд сумын 2-р баг, гуравдугаар байранд Сайншанд сум 1-р баг шалгарсан.</p> <p>Аймгийн Засаг даргын 2021 оны А/40 дүгээр захирамжийн дагуу сагсан бөмбөг, жудо, бокс зэрэг спортын 8 төрөлд амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагч нийт 48 хүнд 6,6 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон.</p> <p>Өсвөр үе, залуучуудын Ази тивийн аварга шалгаруулах Боксын тэмцээн Арабын Нэгдсэн Эмират улсын Дубай хотноо зохион байгуулагдаж нийт 20 орны 600 гаруй тамирчин оролцож, Дорноговь аймгаас 1 тамирчин 5-р байранд орсон амжилт гаргасан.</p> <p>Жудо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээний шагналт 5-р байранд орсон амжилт үзүүлсэн. Чөлөөт бөхийн тамирчин Ч.Отгонтуяад ОХУ-ын Уфа хотод Чөлөөт бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход 2,0 сая төгрөг, БТСГ-ын дасгалжуулагч С.Сайнбаяр Грек улсад болсон Чөлөөт бөхийн мастерсийн тэмцээнд оролцоход 1,5 сая төгрөг, Жудо бөхийн тамирчин О.Сарантуяад Ливан улсын Бейрут хотод Залуучууд, өсвөр үеийн жудо бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь 2,0 сая нийт 12,1 сая төгрөг дэмжлэг үзүүлсэн.</p>
43		3.4.5. Үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх бодлогыг баримтална.	50.0 сая		Төвийн тоо	2020	-	2024	1	<p>Аймгийн аварга шалгаруулах шагайн харваа, үндэсний сурын харваа, чөлөөт бөх, үндэсний бөхийн тэмцээнүүд тус тус зохион байгуулагдаж аваргууд тодорсон ба спортын цолтнууд төрөн гарсан. Улсын наадмын шагайн харваан тэмцээнд аваргалсан баг тамирчдад аймаг байгуулагдсаны 91 жилийн он баяр наадмаар хүндэтгэл үзүүлсэн.</p> <p>Төрийн өмчийн 33 хүүхдийн цэцэрлэгт Монгол ёс заншил, бахархлын өргөө, танхимыг тохижуулан, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3000 гаруй хүүхэд, багачуудад үндэсний өв соёлоо сурталчлан таниулсан.</p> <p>“Соёмбо” цогцолборын хүндэтгэлийн өргөө, “Жаргалан” хүүхдийн зуслан, “Спорт цогцолбор”-ын үндэсний спортын танхимыг түшиглэн үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх “Монгол бахархал” төв байгуулах ажил төлөвлөсөн</p>
44		3.4.6. Иргэдийн		250,1	Сургалтын тоо	2020	701	2024	750	“Хүн амын хоол тэжээл” хөтөлбөрийн хүрээнд Эрүүл

		хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг бүх талаар нэмэгдүүлж, хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжинэ.			Дэмжиж хамтарч ажилласан ААН, байгууллагын тоо		60		80	<p>зохистой хооллолт, таргалалтаас сэргийлэх талаар цаг үеийн нөхцөл байдалдаа уялдуулан зохион байгуулсан 701 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 194 аж ахуйн нэгж байгууллагын 26010 ажилчид иргэд хамрагдаж зөвлөгөө мэдээлэл авсан нь өмнөх оноос 87 удаагийн мэдээлэл, 663 хүнээр нэмэгдсэн.</p> <p>Халдварт бус өвчлөлийг бууруулах зорилгоор мэдээлэл сурталчилгаанд илүүдэл жинтэй 5565 /21.3%/, 1,2-р зэрэгийн таргалалттай 98 /0.3%/ иргэдийг түлхүү хамруулсан.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд эрүүл зохистой хооллолтын үр ашиг, Хооллолтоор дамжуулан эрүүлжих аргын талаар иргэдэд мэдлэг боловсрол олгох зорилгоор 42 сайн дурын ажилтанд мэдээлэл өгч түүгээр дамжуулан 954 иргэнд мэдээлэл сургалтчилгааг түгээж, 13 төрлийн 1542 ш зөвлөмж тараасан.</p> <p>Аймгийн хэмжээнд хоолтой холбоотой өвчлөлийг тандах судалгааг халдварт өвчний EWAR мэдээллийн тогтолцоогоор хоолны хордлогот халдварын хам шинж, сэжигтэй тохиолдлын мэдээлэл авч тандалтыг хийхэд нийтийг хамарсан өвчлөл бүртгэгдээгүй.</p> <p>Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг, Бидний дэлгүүр - 75 ТББ, Чандмана-Эрдэнэ зэрэг хувийн хэвшлийн болон төрийн байгууллагуудыг дэмжиж хамтран ажиллаж 250,1 сая төгрөгийн хүнс тэжээлийн болон эрүүл мэндийн багцын үйлчилгээг 4620 өрхөд үзүүлсэн.</p>
45	3.5. Газрын харилцааны салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүл	3.5.1. Иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн цахим систем, газрын кадастрын нэгдсэн ухаалаг системүүдийг орон нутагт	-	-	Систем нэвтрэлтийн хувь	2020	-	2022	20	<p>Газрын харилцааны ажил үйлчилгээ, мэдээллийг цахимжуулах ажлын хүрээнд 3 төрлийн мэдээллийн сан, 5 төрлийн цахим системийг нэвтрүүлж байна. Иргэд олон нийт нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх, газрын төлбөр, татвар төлөх, газрын харилцаатай холбоотой нийт 17 төрлийн үйлчилгээг цахимаар шуурхай хүргэсэн. Цахим системээр нийт 562 иргэн гэрээ гэрчилгээ, кадастрын зураг хэвлэн авах, 108 иргэн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд саналаа өгч үйлчлүүлсэн.</p> <p>Цахим системээр газрын эрх шилжүүлэх, газрын эрхийн хугацаа сунгах, газрын зориулалт өөрчлөх, газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулах, төлөвлөгөөнд санал өгөх гэх мэт газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн мэдээлэл болон</p>

	ж, хүн амын эрүүл аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	нэвтрүүлнэ.								газрын төлбөр, татвар цахимаар төлөх, цахим дуудлага худалдаанд оролцох эдгээр үйлчилгээг хэрхэн авах талаарх заавар зөвлөмжтэй холбоотой 4 удаагийн өдөрлөг, "Цахим газрын харилцаа-2022" 2 сарын аян, 235 удаагийн мэдээ, мэдээллийг бэлтгэн, байгууллага вэб болон байгууллагын цахим хуудсаар сурталчлан, 13 удаагийн сургалтыг байгууллага, албан хаагчдад хийж, нийт 18349 иргэд, олон нийтэд хүргэх зэрэг арга хэмжээг зохион байгуулж, газрын удирдлагын системийг бүрэн нэвтрүүлсэн.
46		3.5.2. Нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэг, тэмдэгтүүдийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, тооллого хийх утсан цэг тэмдэгтийг сэргээн засварлаж, нийт нутаг дэвсгэрийн бүх төрлийн байр зүйн зургаар бүрэн хангана.	СОНХС-9.9 сая.төг	СОНХ С-9.9 сая.төг	Сэргээсэн цэг тэмдэгтийн тоо	2020	-	2022	30	<p>Дэлгэрэх сумын орон нутгийн хөгжлийн сангийн 9.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аман шанд багт 5 цэг, Цагаан хад багт 5 цэгийг сэргээх ажлыг Талст газар ХХК гүйцэтгэн, хэмжилт хийж баталгаажуулж 2021 онд хүлээлгэн өгсөн.</p> <p>Төрийн өмчийн үзлэг тооллогын ажилтай хамтатган Айраг 53, Аптанширээ 5, Даланжаргалан 9, Дэлгэрэх 8, Замын-Үүд 9, Ихэт 13, Мандах 30, Өргөн 15, Сайхандулаан 20, Сайншанд 25, Улаанбадрах 18, Хатанбулаг 30, Эрдэнэ 11, Хөвсгөл 15 ширхэг нийт 261 цэг тэмдэгт бүр мөсөн утсан, нөхөн сэргээх шаардлагатай байгаа талаар төвийн геодезийн цэг тэмдэгтийн тооллогыг хийж, Замын-Үүд суманд 1, Сайншанд суманд 1 геодезийн цэг тэмдэгтийг орон нутгийн төсвийн 3.0 сая төсөвт өртгөөр 2022 онд сэргээсэн.</p>
47		3.5.3. Газар зохион байгуулалтыг иргэд болон эдийн засгийн хувьд үр өгөөжтэй, экосистемийн тэнцвэрт байдлыг харгалзан оновчтой төлөвлөнө.	-	-	Систем нэвтрэлтийн хувь	2020	-	2022	100%	<p>Газар зохион байгуулалт, геодези, зураг, зүйн газрын даргын 2020 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ын дагуу 14 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 2275 арга хэмжээг төлөвлөлтийн цахим мэдээллийн системд оруулан, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан иргэд олон нийтэд хүргэн ажилласан.</p> <p>Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдээгүй иргэн хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрыг системд бүртгэж, нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хүрээнд "Цахим газрын харилцаа-2022" 2 сарын</p>

										аяныг зохион байгуулж, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн. 2022 оны байдлаар нөхөн бүрдүүлэлтээр оруулах шаардлагатай нийт 601 нэгж талбараас 597 нэгж талбарыг нөхөн бүрдүүлэлтээр бүртгэн, 99,3%-ийн хэрэгжилтийг ханган ажилласан.
48		3.5.4. Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ.	ОНТ-3.0	ОНТ-2.9 сая	Судалгааны ажлын гүйцэтгэл хувь	2020	1	2022	2	<p>Бэлчээрийн фото мониторингийн хээрийн судалгааны ажлыг 14 суманд бэлчээрийн 236 цэгт гүйцэтгэн, програмын боловсруулалтын үр дүнгээс харахад тус аймгийн өвөл, хаврын улирлын боломжит бэлчээрийн даац нь 1483371.5 хонин толгой мал бэлчээрлэх боломжтой, бэлчээрийн даац хэтрээгүй буюу хүртээмжтэй байна.</p> <p>Газар зүйн нэрийг дур мэдэн өөрчлөх, батлагдсан газар зүйн үнэн зөв нэрийг ашиглахгүй, өвөлжөө, хаваржаа гэх мэт үл хөдлөх эд хөрөнгийг нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, үнэн зөв газар зүйн нэрээр хаягжуулахад хүндрэл учирч улмаар газрын маргаан үүсдэг тул газар зүйн нэрийн тодруулалт хийх мэдээллийн сан байгуулах ажлыг эхлүүлж, 14 сумын газарзүйн нэрийн зургийн 9131 мэдээллийг геопортал цахим системийн http://192.168.10.17 серверт байрлуулсан.</p> <p>Ортофото зурагт оруулах ажлыг 2022 оны 1 дүгээр улиралд гүйцэтгэж, боловсруулалтын үр дүнг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн.</p>
49		3.5.5. Хаягийн тэмдгийн суурилуулалтын ажлыг зохион байгуулж, хаягийн мэдээллийн нэгдсэн системд оруулж, олон нийтэд сурталчилна.	ОНТ-55.6 сая.төг	ОНТ-55.6 сая.төг	Хаягжуулалт хийсэн сумын тоо Мэдээллийн санд оруулсан хаягийн мэдээллийн хувь	2020	11 100	2021	12 100	<p>Хаягийн тэмдгийг газар дээр суурилуулах, мэдээллийн санд оруулах ажлыг орон нутгийн төсвийн 35.1 сая төгрөгийн төсөвт өртөгөөр Мандах суманд орон нутгийн хөгжлийн сангийн 20.6 сая төгрөгийн төсөвт өртөгөөр Иххэт суманд "Талст газар ХХК" гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.</p> <p>Даланжаргалан сум шинэ суурьшлын бүс, Иххэт сум 5 гудамжны нэршил 525 нэгж талбар, Сайхандулаан сум 7 нэгж талбарын 1.03 га газар, Улаанбадрах сум 23 нэгж талбарыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шинээр батлуулан, мэдээллийн нэгдсэн санд оруулсан. Хаягжуулалтын тухай хууль, болон Гудамж зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмын дагуу шинээр 1471 нэгж талбарыг дугаарлан хаягийн мэдээллийн системд бүртгэн, 2022 оны байдлаар өссөн дүнгээр 12 суманд хаягийн тэмдгийн суурилуулалтын ажил бүрэн хийгдсэн.</p>

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ

Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын үйлдвэртэй, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлж, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн аймаг болно.

50	4.1. Төсвийн хөрөнгийг орон нутгийн хөгжилд чиглүүлэн үр ашигтай, хариуцлаг атай зарцуулах бодлого баримтална.	4.1.1. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, татвар төлөгчдийг татварт хамруулах хүрээг нэмэгдүүлнэ.	-	-	Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааны цахимжуулалт	2020	80%	2022	100%	<p>“Нэхэмжлэлд суурилсан” татвар ногдуулалт, төлөлтийн системийн ашиглалтыг сайжруулж цахим банкаар татвараа төлөх, тайлагнах боломжийг бүрдүүлсэнээр 10 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор нийт 4828 татвар төлөгч цахимаар тайлангаа илгээсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,5 хувиар өссөн.</p> <p>2022 оныг “Татварын боловсролын жил-2” болгон зарлаж, танхим болон цахимаар 209 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор бичил сегментийн 6995, жижиг сегментийн 510, нийт 7505 татвар төлөгчийг хамруулсан. Хууль тогтоомж мөрдөлтийн түвшингээр 3, 4-р түвшинд ангилагдсан 15011 татвар төлөгчдөд хууль мөрдөлтийн мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>“Цахимаар татвараа төлж цагаа хэмнэе”, “Баримтаа аваарай” уриан дор цахим аяныг зохион байгуулж татвар төлөгчдөд чиглэсэн бүх төрлийн татварын үйлчилгээг 100 хувь цахимаар хүргэсэн.</p>
51		4.1.2. Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн сахилга батыг сайжруулна.	-	-	Төсвийн зарлагын хэмнэлт	2020	2,4%	2022	3,0%	<p>Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, бэлэн байдлыг хангах болон төрийн албан хаагчдын цалин хөлс, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, төсвийн байгууллагуудын халаалтын зардлыг эхний ээлжинд санхүүжүүлэн 2021 оны байдлаар 73,2 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсэн нь 10 хувь буюу 16,3 тэрбум төгрөгийн хэмнэлттэй байсан.</p> <p>Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэн сум, төсвийн байгууллагуудад олгох төсвийн санхүүжилтийг эрэмбэлэх бодлого баримтлан, төрийн албан хаагчдын цалин хөлс, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардлуудыг эхний ээлжинд санхүүжүүлсэнээр 10 дугаар сарын байдлаар 40,8 хувь буюу 39,7 тэрбум төгрөгийг хэмнэж ажилласан.</p>
52		4.1.3. Төсвийн хөрөнгийн	-	-	Шилэн дансны мэдээллийн хувь	2020	99,3	2022	99,5	Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 14 сумын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт

		зарцуулалтад хийх санхүүгийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлнэ.							хийх, мэргэжил арга зүйгэр ханган зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Мөн төрийн аудит, санхүүгийн болон татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах хугацаатай үүрэг чиглэлийг аймгийн Засаг Даргын 2021 оны 01/994 тоот албан бичгээр сумдын Засаг нарт өгч хэрэгжилтийн тайланг хүлээн авсан. 2021 онд санхүүгийн хяналт шалгалтаар 35 төсөвт байгууллага, 18 тусгай сан, 3 ОНӨ-ийн ХХК нийт 38 байгууллагуудад санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж, шалгалтаар 9405.5 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж, орон нутгийн төсөвт 40730.8 сая төгрөгийн, тухайн байгууллагад 123,4 сая төгрөгийн 214 акт, хугацаатай албан шаардлага 23-ыг бичсэн. Нийт тогтоогдсон актны төлбөрийн 93,1 сая төгрөгийг барагдуулж, 3598,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба үүнээс төлөгдөх хугацаа нь болоогүй 188,1 сая төгрөг байна. Санхүүгийн хяналт болон дотоод аудитын төлөвлөгөөний дагуу 55 байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, нийт 390,3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж, орон нутгийн төсвийн орлогын дансанд 351,9 сая төгрөг, тухайн байгууллагын дансанд 38,4 сая төгрөгийг улсын (ахлах) байцаагчийн 200 акт, 15 албан шаардлага тогтоон, орон нутгийн төсвийн орлогын дансанд 38,9 сая төгрөг, тухайн байгууллагын дансанд 13,4 сая төгрөг, нийт 52,3 сая төгрөгийг барагдуулсан. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 14 сумын 133 төсвийн байгууллага, аймгийн төвийн 14 байгууллага, нийт 147 байгууллага нийт 6366 мэдээллийг цахим хуудсанд хуулийн хугацаанд 100% мэдээлж, баталгаажуулсан.	
53	4.2. Төрийн худалдан авах ажиллагааг хариуцлаг ажуулан орон нутгийн аж	4.2.1. Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож "Шилэн тендер шалгаруулалт"-ын бодлого хэрэгжүүлнэ.	-	-	Худалдан авах төлөвлөгөөний дагуу цахимаар зохион байгуулсан тендер шалгаруулалтын хувь	2020	100%	2022	100%	Аймгийн худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан 56 төсөл арга хэмжээг 100 хувь, 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас 73 төсөл арга хэмжээг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтанд байршуулж Сангийн ямаар батлуулсан. Тендер шалгаруулах урилгыг tender.gov.mn болон зууны мэдээ өдөр тутмын сонинд байршуулж олон нийтэд нээлттэй зарлаж ажилласан. Захиалагч талд гаргасан гомдол 4 гарч тухай бүр нь шийдвэрлэн ажилласан.

	ахуйн нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжинэ.									Худалдан авах ажиллагааны сургалтыг 6 удаа цахимаар зохион байгуулж 107 төрийн албан хаагч, иргэнийг хамруулсан. Танхимын сургалтад 256 төрийн албан хаагч, иргэдийг хамруулж шалгалтад 200 албан хаагч, иргэн тэнцэж АЗ-ын серфикат хугацаагүй эзэмших эрхтэй болсон. Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангах зорилгоор нийт 56 тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд “Айсуй цагийн түүчээ”, “Иргэний төлөөлөл”, Дорноговь аймаг дахь “МЭХ”, “Итгэл, сэтгэл, хандлага” төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан хуулийн хэрэгжилтийг 100% ханган ажилласан.
54	4.2.2. Тендер шалгаруулалтад хуулийн дагуу давуу эрх нь тооцогдох боломж бүхий аж ахуйн нэгжүүдийн чадавхыг нэмэгдүүлж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтална.	-	-	Давуу эрхийн зөрүү тооцсон ААНБ-ын тоо	2020	10	2022	10	Зарлагдсан төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгохоор тусгагдсаны дагуу 9 аж ахуйн нэгжээс орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах, дотоодод үйлдвэрлэсэн бараа материал худалдан авах хүсэлт ирж, нотлох баримтуудыг үндэслэн дотоодын давуу эрхийн зөрүүг 868,8 сая төгрөгөөр 2021 онд хийсвэрлэн тооцсон. Энэ онд дотоодын давуу эрх тооцуулах боломжтой 20 төсөл арга хэмжээнд 9 аж ахуйн нэгж давуу эрх тооцуулсан. Тендерт оролцогч 1 аж ахуйн нэгжээс орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах, дотоодод үйлдвэрлэсэн бараа материал худалдан авах хүсэлтийг хүлээн авч дотоодын давуу эрхийн зөрүүг 878,8 сая төгрөгөөр хийсвэрлэн тооцсон.	

55	4.3. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	4.3.1. Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг дэмжиж, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	-	-	Үйл ажиллагаа явуулсан үйлдвэрийн тоо БОМТ дүгнэсэн компанийн тоо, Хамтран ажиллах гэрээний тоо	2020	9 14 0	2022	11 15 4	<p>Ашигт малтмалын чиглэлээр боловсруулах, баяжуулах 11 үйлдвэр, 15 уурхай ажиллаж нийт 121386.9 тн ашигт малтмалын бүтээгдэхүүнийг олборлосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 хувиар өссөн. Даланжаргалан суманд төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр шинээр ашиглалтад орж үйл ажиллагаагаа эхлүүлсэн.</p> <p>Айраг, Даланжаргалан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Сайншанд, Өргөн, Иххэт сумын нутагт ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 16 компанийн 2021 онд гүйцэтгэсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хүлээн авч, аймгийн Засаг даргын 2019 оны А/938 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 1 компанийн ажлыг дүгнэсэн.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу "МАК цемент" ХХК, "Эрдэнэс цагаан суварга" ХХК, "Олон ихт баян" ХХК, "Доншен газрын тос (Монгол)" ХХК-уудтай Хамтран ажиллах гэрээг байгуулсан.</p>
56	4.3.2. Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВт-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барихад орон нутгаас дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	45	0	Гүйцэтгэлийн хувь	2020	0	2022	100	<p>Чойр-Сайншанд чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих зориулалтаар 7.8 га газрыг орон нутгаас 2021 онд шийдвэрлэж газрын гэрчилгээг олгосон.</p> <p>Цахилгаан дамжуулах агаарын шугамын холбогдох трассыг 2022 онд хянаж батлуулан дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.</p>	
57	4.3.3. Нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн	-	-	Дэд бүтцийн ажлын гүйцэтгэлээр	2020	100	2022	100	<p>Иххэт суманд "Монголросцветмет" ТӨҮГ-ын харьяа "Бор-Өндөр" УБҮ-ийн Зүүн цагаан дэлийн уурхайн эрчим хүч хангамжийн асуудлыг шийдэх хүртэл 8 дугаар худгийн шугамнаас 3552 метр, 72 ширхэг агаарын шугам тавих зөвшөөрөл олгож үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Мөн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр</p>	

		бүтээн байгуулалтын дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг дэмжиж эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлнэ.								<p>замын барилга угсралтын ажил бүрэн хийгдэж улсын комисс хэсэгчилсэн байдлаар ажиллуулахаар бэлтгэл ажлууд хангагдсан.</p> <p>Зүүнбаян-Ханги чиглэлийн хүнд даацын хатуу хучилттай авто замын төслийг барилга угсралтын болон замын ажил хийгдэж дууссан.</p> <p>Сайншанд сумаас Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт-Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичиг" чиглэлд баригдах нийт 846 км төмөр замын эхний хэсэг болох Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрээс Дэлгэрэх сум хүртэлх 120 км төмөр замын зураг төсвийг Улаанбаатар төмөр зам ХНН-ийн зураг төслийн төв гүйцэтгэсэн.</p> <p>Цагаан суварга-Ханги мандал чиглэлийн төмөр замын маршрутыг тэмдэгжүүлэх ажил хийгдсэн. Уул уурхайн салбарын 7 компаниас бүтээгдэхүүн тээвэрлэх замын маршрут тогтоох хүсэлтийг хүлээн авч сум болон байгууллагуудаас ажлын хэсэг ажиллаж нийт 5 чиглэлд 649,2 км шороон замаар тээвэрлэлт хийх маршрутыг баталж уул уурхайн экспортын бүтээгдэхүүнийг хайрган хучилттай буюу сайжруулсан замаар хучаастай тээвэр хийж байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэхээс сэргийлсэн арга хэмжээг авч ажиллах чиглэл хүргүүлэн хяналт тавин ажилласан.</p>
58		4.3.4. Зарим сумдын дулааны болон цахилгааны эх үүсвэр, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх судалгааны ажлыг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлэн сумдын хөгжлийг дэмжинэ.	Хөвсгөл сум 166 сая, Улаанбадрах сум 130сая төгрөг.	150 сая	Гүйцэтгэлийн хувь	2020	0	2022	100	<p>Дэлгэрэх сумын төвлөрсөн дулаан хангамжийн ажлыг "Чандмань-Илч" ОНӨХХК гүйцэтгэж халаалтын улирал эхлэхэд төсвийн 8 байгууллагыг хангасан. Алтанширээ сум төвлөрсөн дулаан хангамжид төсвийн 5 байгууллагыг холбосон.</p> <p>Хөвсгөл сумын төвлөрсөн шугам сүлжээний гадна цахилгаан хангамжийн ажил, Улаанбадрах сумын цахилгаан дамжуулах агаарын шугам солих, дэд станц барих ажлын судалгааны дагуу зураг төслийг "Электро" ХХК боловсруулж, орон нутгийн төсвийн 295.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр "Смарт Крафт" компани гүйцэтгэж ашиглалтад оруулсан.</p>
59		4.3.5. Эрчим хүчний салбарт			Хэрэгжүүлсэн ажлын тоо	2020	-	2022	2	Айраг салбарын сүлжээний усны насос шинэчилж, давтамж хувиргуур суурьлуулсан. Сайншанд сумын усны

		хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, үргүй зардлыг багасгана.	Айраг сум 13 Сайншанд сум 5,2 2 32 Дэлхийн банкны 4,5 тэрбум төгрөг						4	<p>насос, нэмэлт усны насос шинэчилсэн. Дулааны эх үүсвэр 2-ын цахилгаан тоноглол бүрд давтамж хувиргуур суурилуулан, усны алдагдлыг бууруулсан.</p> <p>Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 481 дүгээр тогтоолын хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд 2302 өрхийн 1,364,150.10кВт.ц ашиглалтад 103,7 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн цахилгаан халаалтыг ашиглахад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2020 оны 221-р тогтоолын хэрэгжилтээр аймгийн хэмжээнд 9554 аж ахуйн нэгж байгууллага, 113932 өрх, нийт 123486 хэрэглэгчдийг 4,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлтөд хамруулсан.</p> <p>Дэлхийн банкны 6.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Эрчим хүчний төсөл-2 хэрэгжиж Сайншанд, Замын-Үүд сумын цахилгаан дамжуулах дэд өртөөний өргөтгөл, эрчим хүч хэмнэх ухаалаг тоолуурын системийг бий болгох 10 кВ-ын ЦДАШ-ын ажлын гүйцэтгэл 21.4%-тай; 0,4 кВ-ын ЦДАШ-ын ажлын гүйцэтгэл 49.5%-тай; Ухаалаг тоолууржуулалт 11%-тай 0,4 кВ-ын кабель шугам 50%-тай; 10кВ-ын кабель шугам 50%-тай байна.</p> <p>Цахилгаан дамжуулах агаарын шугамын хүчдэлийг хэмжээг 0,4кВт-аас 10кВт болгож нэмэгдүүлэх, нэмж дэд станц барьснаар цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн тасралтгүй, найдвартай эх үүсвэрийг бүрдүүлсэн.</p>
60	4.4. Банк санхүүгийн найдвартай байдлыг сайжруулна.	4.4.1. Банкны үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх замаар иргэдийн хуримтлал үүсгэхэд анхаарч бэлэн бус төлбөр тооцоог дэмжинэ.			Иргэд, ААНБ-ын харилцах, хадгаламжийн үлдэгдэл	2020	155,0 тэрбум	2022	165,0 тэрбум	<p>Харилцах дансны үлдэгдэл 53.1-62.2 тэрбум төгрөг болж 9.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, Хадгаламжийн үлдэгдэл 180.2-160.8 тэрбум төгрөг болж 19.4 тэрбум төгрөгөөр буурсан нь иргэдийн орлого буурсантай холбоотой байна.</p> <p>Банкны үйлчилгээ, цахимжуулах болон хуримтлал үүсгэх ач холбогдлын талаарх мэдээлэл, зөвлөгөөг иргэдэд олон нийтийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн байгууллагаар тогтмол хүргэн ажилласан.</p> <p>2022 оны байдлаар интернет банкны хэрэглэгч 52952, ПОС төхөөрөмж хэрэглэгч 1696, АТМ 68, мобайл банкны хэрэглэгч 38767, мобайл банкны хэрэглэгч 2,508-аар буурч, ПОС төхөөрөмж хэрэглэгчийн тоо 282-оор өсч, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл 62,2 тэрбум төгрөг,</p>

										хадгаламжийн үлдэгдэл 160,8 тэрбум төгрөг болсон.
61		4.4.2. Иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэн санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлнэ.			Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2020	0	2022	1000	<p>Санхүүгийн боловсролыг сайжруулах, санхүүгийн эрсдэл дарамтад орохоос сэргийлэх асуудлаар 1218 иргэнд цахим сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 26569 иргэнд сурталчилгааны ажлыг хүргэж цахим сүлжээнд байршуулж ажилласан. Мөн "Ятгах тусам нягтал" арга хэмжээг хэрэгжүүлж 22517 иргэнд залилангийн гэмт хэрэгт өртөхөөс хамгаалан, масс мессеж хүргүүлж банкны харилцагч нарт 4052 ширхэг танилцуулгыг тараасан.</p> <p>Засгийн газар, Монгол банкнаас явуулж байгаа төсөв санхүүгийн бодлого, хэрэгжилтийг ард иргэдэд танилцуулан, арилжааны 6 банкнаас "Global money week", "Дэлхийн хуримтлалын өдөр" аяныг зохион байгуулж, нийт 2981 хүүхэд, 200 иргэн, 1989 оюутан сурагчдад санхүүгийн мэдээлэл, нээлттэй хаалганы өдөрлөгөөр өөрсдийн үйлчилгээг 5000 гаруй иргэдэд сурталчилж, сурталчилгааны материалыг тараасан.</p> <p>Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мессежийг 23883 иргэнд масс мессежээр хүргэж, "Санхүүгийн залилан, луйврын шинжтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдвийн хүрээнд Анагаах шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургуулийн 300 гаруй оюутнуудад мэдээлэл өгсөн.</p>
62		4.4.3. Иргэдийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд анхаарч, хугацаа хэтэрсэн зээлийг бууруулж, зээлжих чадварыг нэмэгдүүлнэ.	-	-	Банкны чанаргүй зээлийн үлдэгдэл	2020	5,6%	2022	5,5%	<p>Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (Ковид-19) -ын цар тахлын үед жилийн боомтын үйл ажиллагаа зогсонги байдалд орж, иргэдийн орлого буурснаас шалтгаалж, зээлийн эргэн төлөлт удаашрах, Засгийн газраас хэрэгжүүлсэн ипотекийн зээлийг хойшлуулсан зэрэг үзүүлэлтээс шалтгаалан, Замын Үүд дэх банкны хугацаа хэтрэлт 13,1 тэрбум төгрөг болж, нийт багцад эзлэх хугацаа хэтрэлт 12,9%-д хүрсэн нь аймгийн нэгдсэн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлсөн.</p>
63	4.5. Даатгалын хариуцлагын тогтолцоог сайжруула	4.5.1. Албан журмын даатгалын холбоо, даатгал, хөрөнгийн үнэлгээний	-	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2020	1	2022	3	<p>Санхүү, төрийн сангийн хэлтэс, Замын цагдаагийн тасаг, хөрөнгийн үнэлгээний компани, даатгалын компаниудын хамтын ажиллагааны хүрээнд уулзалт зохион байгуулж 2021 онд хөрөнгийн үнэлгээний хохирлын хэмжээ 300,0 мянган төгрөгөөс доош, 2022 онд 500,0 мянган төгрөгөөс тогтоогдсон тохиолдолд учирсан хохирлыг даатгалын</p>

	Н, хамрах хүрээг нэмэгдүүл нэ.	компаниудын хохирол барагдуулах ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.								компани орон нутагтаа шийдвэрлэн барагдуулсан. Аймгийн хэмжээнд хөрөнгийн үнэлгээний 3 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2021 онд 16 аж ахуйн нэгж байгууллага, 115 иргэний хөрөнгөнд нийт 329,5 сая төгрөгийн хохирлын үнэлгээ тогтоосон. Даатгалын компаниуд иргэн, аж ахуйн нэгжтэй 17906 гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд жолоочийн хариуцлагын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, даатгалын бүтээгдэхүүнийг сурталчлахаар "Өнөөгийн Ялалт" сонинд 6 удаа нийтлэл хэвлүүлэн, аймгийн DTV, DSB телевизээр 3 удаа мэдээ нэвтрүүлж, иргэдийг даатгалд хамруулах нөлөөллийн ажлыг зохион байгуулснаар давхардсан тоогоор 1000 гаруй иргэдийг даатгалд хамруулсан.
64		4.5.2. Даатгалын байгууллагын нөхөн төлбөр олголтыг сайжруулна.	-	-	Нөхөн төлбөрийн олголтын хувь	2020	80%	2022	85%	Орон нутгийн даатгалын салбаруудад 2021 онд жолоочийн хариуцлагын даатгалын тохиолдлын нөхөн төлбөр авах хүсэлт ирүүлсэн 167 даатгуулагчийн холбогдох баримт бичгийг хянан үзэж 152 даатгуулагчид 83,7 сая төгрөгийг нөхөн төлбөр, 2022 онд 69 даатгалын тохиолдолд 75,1 сая төгрөгийн нөхөн төлбөрийг иргэн, аж ахуйн нэгжид олгосон.
65		4.5.3. Иргэдийг даатгалд хамруулах нөлөөллийн ажлыг дэмжинэ.	-	-	Даатгалд хамруулсан иргэдийн тоо	2020	600	2022	2000	Орон нутгийн телевиз болон сонин хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр дамжуулан жолоочийг хариуцлагын даатгалд хамруулах нийт 17 удаагийн сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулж 2056 иргэнд мэдээлэл хүргэсэн. Орон нутгийн даатгалын компаниуд даатгалын бүтээгдэхүүнийг сурталчлах, даатгалд хамруулах нөлөөллийн ажлыг зохион байгуулснаар давхардсан тоогоор 14800 гаруй иргэдэд мэдээлэл хүргэж, 2210 иргэнийг даатгалд хамруулсан.
66	4.6. Хөрш болон бүс нутгийн орнуудтай эдийн засгийн болон олон талт	4.6.1. Хөрш болон өндөр хөгжилтэй орнуудтай уламжлалт харилцаагаа үргэлжлүүлж, шинээр бусад	-	-	Гэрээ, санамж бичгийн тоо	2020	8	2022	10	Аймгийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг гадаад харилцааны хэрэгслээр дэмжиж 9 хот дүүрэг, 15 олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй харилцаа тогтоон гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэн, Дорноговь аймаг болон Эрхүү хотын хооронд худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан техник, нийгэм, хүмүүнлэг, соёлын салбарт хамтран ажиллах Санамж бичгийг байгуулсан.

	хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	улсуудын муж, хотуудтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.								<p>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хоттой найрсаг харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх зорилгоор хамтран ажиллах Санамж бичгийг байгуулахаар харилцан тохиролцсон.</p> <p>Дорноговь аймаг болон Шизуока мужтай найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа тогтоосны 10-н жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлж, цар тахлын улмаас зогсонги байдалд орсон хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн Шизуока мужид 13 албан хаагчийг сургаж, Шизуока мужаас 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй холбогдох салбарын удирдлага, мэргэжилтнүүдийн 3 удаагийн албан ёсны айлчлал зохион байгуулсан.</p> <p>БНХАУ-н Сычуань мужийн Жанжякоу хоттой 2 талын цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд харилцан санал солилцох, ӨМӨЗО-ны Хөх Хотын Гадаад харилцааны албатай гадаад хамтын ажиллагааг сэргээх, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газартай муж, хот, хошуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх асуудлаар тус тус цахим хурал зохион байгуулсан.</p> <p>Бүгд Найрамдах Турк Улсын Сакарья хотын захирагчтай аймаг, хотын хооронд боловсрол, эрүүл мэнд, спорт, аялал жуулчлал, түүх, соёл урлагийн салбарт хамтран ажиллах, мэргэжилтэн солилцоо, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ах дүү хотын харилцаа тогтоох, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийг байгуулсан.</p>
67		4.6.2. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудтай холбож, үр ашигтай хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд бодлогоор	-	-	Хамтын ажиллагаатай байгууллагын тоо	2020	13	2022	15	<p>Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд болон ТИКА олон улсын байгууллагын суурин төлөөлөгчид аймагт ажиллах үеэрээ Сайншанд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн урлаг танхимыг тохижуулах, 13 дугаар цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбайг барих ажлын санхүүжилтийг шийдвэрлэн, цаашид боловсрол, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллаж, томоохон төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэхээр болсон.</p> <p>НҮБ-ын Цөлжилттэй Тэмцэх Конвенцийн санхүүжилтээр НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага, БОАЖЯ-наас хэрэгжүүлж буй “Монгол орны хуурай бүс нутгаас үүдэлтэй</p>

		дэмжинэ.								<p>элсэн ба шороон шуурганаас урьдчилан сэргийлэх, бууруулах” төсөл Замын-Үүд суманд 2021-2023 онд хэрэгжих бөгөөд нийт 6 га газар ногоон зурвас байгуулах, мод бойжуулах болон хүнсний нарийн ногоо тарих боломжтой нэгдсэн тог усалгааны системтэй хүлэмж хийгээд 2км урттай автозам дагуу ногоон зурвас байгуулах ажлууд хийгдэж, одоогийн байдлаар ургалт 70%-тай, 2 төрлийн 9700 гаруй ургамал тариалалт хийгдсэн.</p> <p>“Оюу толгой” ХХК, Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн (WCS) Монгол дахь төлөөлөгчийн газрын санхүүжилтээр “Өмнийн говийн бүс нутагт хууль бус ан, зэрлэг амьтдын эд эрхтэн бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх төсөл”-ийг аймгийн Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Эрдэнэ, Өргөн, Мандах сумдад 2021-2022 онд хэрэгжүүлэх анхан шатны уулзалтыг зохион байгуулж, хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан.</p> <p>Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ийн хүрээнд Замын-Үүд, Сайншанд сумдын 0.4 кВ-ын 66.5 км, 10 кВ-ын 11.2 км ЦДАШ шинэчлэх, 8104 өрх, 763 аж ахуйн нэгжид ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх 6.3 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж, барилга угсралтын ажил эхэлсэн. Ажлын гүйцэтгэл 30%-тай байна.</p>
--	--	----------	--	--	--	--	--	--	--	---

ТАВ. ЗАСАГЛАЛ

Зорилго 5. Хүний хөгжлийг хангасан ухаалаг, тогтвортой, сайн засаглалыг бэхжүүлэн, цахим технологид тулгуурласан төрийн үйлчилгээг эрчимжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа өргөжүүлнэ.

68	5.1. Төрийн тогтвортой бодлого бүхий ухаалаг засаглалыг бэхжүүлж, олон нийтийн оролцоо,	5.1.1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, үр дүнг дээшлүүлнэ.	ОНТ	-	Хэрэгжилтийн хувь	2020	80	2022	100	<p>Агентлаг байгууллагын дарга нартай 18 удаа, сумдын Засаг дарга нарт 14 удаагийн хурлыг зохион байгуулан, ажил үүргийн чиглэл, бодлого шийдвэрийг танилцуулан ажилласан.</p> <p>Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 удаа зохион байгуулж 93 иргэн тэнцэн төрийн албаны нөөцөд бүртгэгдсэн. Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх, туслах албан тушаалыг нөхөхөөр 12 удаагийн тусгай шалгалтыг зохион байгуулж 98 сул орон тоог нөөцөөс болон шатлан дэвшүүлэх замаар, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг нөхөхөөр 2 удаа төрийн үйлчилгэний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг зохион</p>
----	---	---	-----	---	-------------------	------	----	------	-----	---

	хяналтыг төлөвшүүлнэ.									байгуулж 7 сул орон тоог тус тус нөхсөн.
69	5.1.2. Орон нутгийн бодлого шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна.	ОНТ	-	Иргэдийн оролцооны хувь	2020	20	2022	75	<p>Төрийн үйлчилгээг хүргэхээр аймгийн 15 төрийн байгууллагын 73 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн (e-mongolia.mn) системд нэвтрүүлэн 268 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан авах боломжийг бүрдүүлж төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан 353 төрлийн лавлагаа, мэдээллийг давхардсан тоогоор 269007 иргэдэд хүргэсэн.</p> <p>Айраг, Сайхандулаан сумдын “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д иж бүрэн компьютер, хэвлэгч төхөөрөмж, хурууны хээ, иргэний үнэмлэх уншигч, тоон гарын үсгийн гэрчилгээ тээгч зэрэг төрийн үйлчилгээг операторын хэлбэрээр үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлж, ажиллах нөхцөл, иргэдийн үйлчлэх боломжийг бүрдүүлснээр аймгийн бүх сумдад операторийн үйлчилгээ бүрэн нэвтэрсэн.</p> <p>Төрийн үйлчилгээний лавлах суурин утсыг ажиллуулан “call center” үйлчилгээгээр дамжуулан нэг дороос төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 942 дуудлагад хариу өгч ажилласан.</p>	
70	5.2. Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой тодорхойлж, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэй гээ	5.2.1. Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	2.0 сая	-	Шинжилгээ хийсэн байгууллагын тоо	2020	-	2022	8	<p>Төрийн албан хаагчийн ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэгт дүн шинжилгээг төрийн захиргааны 7 байгууллага хийж албан тушаалын болон ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж ажилласан. Тайлант хугацаанд чиг үүргийн шинжилгээ хийж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгах бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэн ажилласнаар нийт 48 ажлын байрны тодорхойлолтыг шинэчилсэн.</p> <p>Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцэд чиг үүргийг шинжилгээ хийсний үндсэн дээр аймгийн Засаг даргын 2022 оны А/230 дугаар захирамжаар дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын ангилал зэрэглэлийг өөрчлөн, төрийн цахимаар хүргэх операторын үйлчилгээ, сумын Засаг даргын Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг хариуцуулахаар жишиг албан тушаалын тодорхойлолт, 39 төрийн захиргааны албан тушаалын ажлын байрны шинжилгээг асуулгын аргаар авч 3 албан тушаалын чиг үүргийг салгаж, 2 албан тушаалын чиг үүргийг</p>

	хамтран ажиллах тогтолцоог төлөвшүүлнэ.									<p>өөрчилж, 3 албан тушаалыг шинээр бий болгон аймгийн Засаг даргын 2022 оны А/256 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог үйл ажиллагааны давхардал, хийдэлгүй байхаар шинэчлэн баталсан.</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны яамнаас аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тоог жишиг байдлаар баталсантай холбогдуулан бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын 2022 оны А/340 дүгээр захирамжаар баталж давхардал, хийдлийг арилгасан.</p>
71	5.2.2. Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, төр, иргэний хамтын ажиллагааны оновчтой арга хэрэгсэлийг нэвтрүүлнэ.	ОНТ	-	<p>-Иргэдийн өргөдөл, гомдлын барагдуулалтын хувь</p> <p>-төрийн байгууллагуудын талаарх иргэдээс авсан судалгааны үр дүнг тооцсон байна</p> <p>-ТББ-аар гүйцэтгүүлсэн ажлын тоо- 5</p>	2020	93	1	2022	94	<p>Албан тушаалын тодорхойлогод заагдсан чиг үүргийн хүрээнд "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хууль, энэхүү хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдон гарсан зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Тамгын газарт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хянан шийдвэрлэх тухай журмыг мөрдөн ажиллалаа.</p> <p>Иргэдээс орон нутгийн төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ тайланг улирал бүр аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажиллав.</p> <p>Аймгийн төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын талаарх хэрэглэгчийн үнэлгээний судалгааг авах ажлыг зохион байгуулан ажилласан.</p>
72	5.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогыг хэрэгжүүл	ОНТ	-	Цахим үйлчилгээний тоо	2020	52		2022	86	<p>Төрийн цахим үйлчилгээ үзүүлдэг операторын ажилтны үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөл байдал, сурталчлах ажлын чиглэлээр хяналт шалгалтыг хийж гарсан 5 алдаа дутагдлыг тухай бүр нь засах арга зүйн туслалцаа үзүүлж төрийн цахим үйлчилгээг хүргэхэд гарсан программын 12 алдаа, техникийн 5 алдааг цахимаар холбогдон засварлаж, заавар зөвлөмжийг нийт 17 удаа өгсөн.</p> <p>Төрийн цахим үйлчилгээг орон нутгийн телевиз, радио, сонин, цахим хуудсаар 20 постер мэдээлэл, 4 видео шторк, 1000 гарын авлага, 400 зурагт хуудсыг 60000 иргэдэд хүргэсэн.</p>

	ж, төрийн үйлчилгээний цахим хэрэглээг нэмэгдүүлнэ.	цахим хэрэглээг нэмэгдүүлнэ.								<p>Төрийн төлбөр тооцоог өөрөө өөртөө үйлчлэх нэг дороос төлөх боломжтой “Гэрэгэ системс” ХХК-ийн 5,5 сая төгрөгийн ухаалаг “КИОСК” тоног төхөөрөмжийг Сайншанд сумын ЗДТГ-ын Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд суурилуулан цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>“Төрийн цахим үйлчилгээг иргэдэд сурталчлах өдөрлөг” – ийг Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар, “Гэрэгэ системс” ХХК-тай хамтран зохион байгуулж нийт 150 гаруй иргэнд төрийн цахим үйлчилгээг сурталчилж ажилласан. 13 сумын "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн оператороор нийт 75 цахим үйлчилгээг хүргэсэн нь өмнөх оноос 23 төрлөөр нэмэгдсэн.</p>
73		5.3.2. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах, хянах нөхцөлийг бүрдүүлнэ.	ОНТ	20.0	Цахим хаягтай сум байгууллагын тоо	2020	16	2022	40	<p>Төрийн байгууллагуудын мэдээлэл технологи хариуцсан албан хаагчдын нэгдсэн уулзалтыг зохион байгуулж төрийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн байгууллага хоорондын цахим уялдаа холбоог сайжруулах чиглэлээр заавар, зөвлөмжийг өгсөн. Төрийн байгууллагын албаны цахим хуудсыг Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан, Өргөн, Эрдэнэ, Хатанбулаг сум болон 18 агентлагууд нэвтрүүлсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын албаны цахим хуудасны шинэчлэлт хөгжүүлэлтийг “Ухаалаг Засаглал” ТББ-аар гүйцэтгүүлэн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлсэн.</p> <p>Олон нийтэд төрийн байгууллагын ил тод байдлыг хангаж орон нутгийн DTV, DSB телевиз, "Өнөөдрийн ялалт", "Өнөөгийн Дорноговь" сонинд сар бүр онцлох үйл ажиллагааны 231 мэдээ мэдээллийг нийтэлж 27500 иргэдэд хүргэж ажилласан.</p> <p>Хэвлэл мэдээллийн "www.dornogovipost.mn", "www.dornogovi.gov.mn", "www.montsame.mn", "www.facebook.com/Дорноговь ЗДТГ", www.facebook.com/Дорноговь АОК" цахим хуудсанд цаг үеийн нөхцөл байдлын 1586, шторк болон постер хэлбэрээр 955 мэдээлэл бэлтгэн оруулж нийт давхардсан тоогоор 301887 иргэнд хүргэсэн бөгөөд үүнээс 106731 иргэнд цахимаар нэмэлт мэдээлэл хүргэсэн.</p> <p>Иргэдийн олон нийтийн оролцоог хангах зорилгоор "Хайр нэмье-хүчирхийллийг хасъя", "Бүү март", "Хүн хүндээ</p>

										<p>хүндэтгэлтэй хандъя", "Ногоон Дорноговь", "Халдварыг хамтдаа давъя", "Ирээдүйгээ хамгаалъя", "Хамтдаа давъя" зэрэг цахим нөлөөллийн аяныг зохион байгуулж давхардсан тоогоор аймгийн хэмжээнд нийт 543300 хүнд хүрсэн.</p> <p>Төрийн байгууллагын албаны цахим хуудсыг 6 сум, 18 агентлагт нэвтрүүлсэн нь өмнөх оноос 19 хувиар, "Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем"-ийг төрийн болон төрийн өмчит 125 байгууллагад нэвтрүүлэн албан бичиг солилцох, өргөдөл гомдол бүртгэх, цаг бүртгэл хөтлөх байдлаар ашиглаж байгаа ба төрийн байгууллагуудад цахим хэрэглээг нэмэгдүүлсэн.</p>
74	<p>5.4. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.</p>	<p>5.4.1. Төрийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлтэд хяналт шинжилгээ хийж, чадахуйн зарчимд тулгуурласан мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлнэ.</p>	120,0	120,0	Бэлтгэсэн хүний нөөцийн тоо	2020	40	2022	100	<p>Төрийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлтэнд хяналт шинжилгээ хийж, Орон нутагт дутагдалтай байгаа салбарын мэргэжлийн судалгаанд үндэслэн багш, эмч, хөдөө аж ахуй, газар зохион байгуулалт зэрэг мэргэжлээр суралцаж байгаа 99 оюутанд төрийн албанд шаардлагатай байгаа хүний нөөц бүрдүүлэх зорилгоор сургалтын төлбөрт нь 177.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн 9-12 дугаар ангийн бүх сурагчдад "Ажлын чиг баримжаа олгох" сургалтыг 2 удаа, телевизийн цахим зөвөлгөөн 2 удаа, 8 төрлийн мэргэжлийн нэр хүндтэй зочин оролцуулсан подкаст танилцуулга, "Ажлын гараа-нутгийн хөгжил" оюутан залуучуудад зориулсан уулзалт зэрэг ажлыг зохион байгуулан ажилласнаар дутагдалтай байгаа мэргэжлийг сонгож суралцахад чиглүүлж ажилласнаар хүний нөөцийн зорилтот түвшиндээ хүрч чадсан.</p> <p>Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 удаа зохион байгуулж 389 иргэн хамрагдаж 100 иргэн тэнцэж нөөцөд бүртгэсэн. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын 195 сул орон тооны албан тушаалд тусгай шалгалтыг 4 удаа зохион байгуулж 53 сул орон тоог нөхсөн.</p> <p>Сувилахуйн чиглэлээр Дорноговь аймгийн 15 оюутан төгссөн ба үүнээс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 10, сумын эрүүл мэндийн төвүүд 1, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт 2 сувилагч, сумын эрүүл мэндийн төвүүдэд шинэ төгссөн 3 эмч, 3 тусгай мэргэжилтэн ажилд орсон. Эм найруулагчийн ангид 2020-2023 онд суралцаж байгаа 16 оюутантай орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах гэрээг байгуулан сургалтын төлбөрийн 100% -ийн тэтгэлэг болох 67.9 сая</p>

										төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас олгож, орон нутгийн хүний нөөц бэлтгэх ажлыг бодлогоор дэмжсэн.
75	5.4.2. Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг сайжруулан, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, мэргэшүүлж, чадавхжуулах тогтолцоог хөгжүүлэн хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлнэ.	ОНТ	-	Сургалтад хамрагдсан албан хаагчийн хувь 85%, Хөтөлбөрийн тоо	2020	80%		2022	90%	<p>Аймгийн хэмжээнд буюу 14 сум, 28 агентлаг байгууллагууд "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах бодлогыг баримтлан нийт 280 гаруй сургалт зохион байгуулахаар төлөвлөгөө гаргаж ажилласан.</p> <p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/233 дугаар захирамжаар 2022 онд зохион байгуулах сургалт, зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөөг 42 арга хэмжээтэй байхаар төлөвлөн баталж 40 сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж 100,0 сая гаруй төгрөгийг зарцуулж 200 гаруй төрийн албан хаагчдыг ажлын байран дээр нь сурган чиглэл бүрээр мэргэшүүлж ажиллалаа.</p> <p>Удирдлагын академийн эрхэлсэн болон ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 12, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 22, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 32, шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 40 албан хаагчийн мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн.</p> <p>Төрийн бодлого, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй боловсруулж, хэрэгжүүлэх болон төрийн алба, өөрчлөлт шинэчлэлтэд зохицож чадах үнэт зүйл, мэдлэг, чадвар бүхий хүний нөөцийг төлөвшүүлэх зорилгоор "Дорноговь аймгийн төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах" аймгийн зорилтот хөтөлбөрийг боловсруулан төрийн албан хаагчдыг сургах, орон нутагт дутагдалтай байгаа мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тэтгэмж олгох зэрэг бодлогын зорилтыг тусган аймгийн ИТХ-н 2022 оны 09/01 тогтоолоор батлуулсан.</p>
76	5.4.3. Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт	ОНТ	-	Албан даалгавар Сургалтын тоо	2020	Албан даалгавар 1,		2022	Албан даалгавар 1,	<p>Аймгийн Засаг даргын 2021 оны 01, 02 дугаар албан даалгаврын хүрээнд 14 сум, 28 агентлагаас ажлын төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргуулж үр дүнг тооцож ажилласан. Сумдад холбогдох заалт бүрийн биелэлтэд хяналт шалгалт хийж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн арга зүйн зөвлөгөө өгч, зөрчил гаргасан 23 төрийн албан хаагчид сахилга хариуцлагын арга хэмжээг авсан. Ёс зүйн зөрчил гаргасан нийт 26 төрийн</p>

		хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж, төрийн үйлчилгээний чанарыг ахиулж шинэ соёл төлөвшүүлнэ.					Сургалтын тоо-20	Сургалтын тоо-20	албан хаагчдыг уучлал хүсэх 6, сануулах 17, нэг сарын цалингийн 19, 20 хувь суутгах 3 арга хэмжээг авч ажилласан. Төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах болон бусад хүний нөөцтэй холбоотой асуудлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/248 дугаар захирамжаар Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт, аймгийн Засаг даргын Тамгын газрын баталсан удирдамжийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мал эмнэлгийн газрын хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулахад хууль бус томилгоо нийт албан хаагчийн 5-8 хувийг эзэлж байгаа нь илэрсэн. Төрийн албан хаагчийг төрийн албанаас түр чөлөөлөхдөө нотлох баримт бүрдүүлдэггүй, сул орон тоо гарсан тухай тушаал шийдвэрийн бүрдэл хууль эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн, ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ бодит үр дүнг харгалздаггүй, ялгавартай үнэлж, дүгнэсэн, нөөцийн мэдээллийг тухай бүр нь мөн сул орон тоо гарсан тухай мэдээлэл, сул ажлын байрны захиалгыг Төрийн албаны тухай хууль заасан хугацаанд Төрийн албаны салбар зөвлөлд мэдээлдэггүй, нуун дарагдуулдаг зэрэг зөрчлүүд гарсан тул зөрчлийг хууль тогтоомжийн дагуу арилгах арга зүй, чиглэл өгч ажилласан.	
77	5.5. Хүний эрхийг хамгаалах чиглэлд иргэн, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, оролцоог хангана.	5.5.1. Бүх нийтийн оролцоог хангасан, үр нөлөөтэй, хариуцлагатай, чадварлаг бүтцийг бүх шатанд бий болгож, иргэдийг аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлөөр хангана.	80,0	83,4	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ	2020	9 120,0	2022	5 83,4	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд салбар дундын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд 360 мэдээлэл бэлтгэн цахимаар олон хандагчтай 16-37 зарын группэд байршуулан 496002 иргэнд мэдээ мэдээллийг хүргэсэн. Орон нутгийн DSB, DTV телевизүүдтэй хамтран 30 удаагийн 55 минутын мэдээллийг бэлтгэн 26 удаагийн давтамжтайгаар хүргэн ажилласан. Хүний эрхийн Олон улсын өдрийг утаж сургалт, нөлөөллийн ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулж, “Хүний эрхийн төлөө хамтдаа” уриан дор зохион байгуулж төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд “Өглөөний уулзалт” арга хэмжээг хамтран зохион байгуулсан. Хүний эрхийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, цаашид хийхээр төлөвлөж

										байгаа арга хэмжээнүүдийн талаар холбогдох байгууллагууд харилцан мэдээлэл солилцсон. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор Ахмадын хороонд 70.4 сая төгрөг, Эмэгтэйчүүдийн зөвлөлд 8,0 сая төгрөг, Улаан загалмайн хороонд 5,0 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын шийдвэрээр орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлсэн.
78	5.6. Төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх замаар шударга ёсыг бэхжүүлнэ.	5.6.1. Шударга, хариуцлагатай нийтийн албыг бэхжүүлж, төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, ил тод, нээлттэй байдлыг хангана.	-	-	Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувь	2020	90%	2022	90	Аймгийн Засаг даргын 2021 оны А/47 дугаар захирамжаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 97.8 хувьтай. Шударга өрсөлдөөний чиглэлийн 2 удаагийн цахим сургалт, 1 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулан, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбогдуулан хэлтэст ирүүлсэн 2 өргөдлийг хүлээн авч судалж, хуулийн хугацаанд зохих хариуг өгч шийдвэрлэсэн бөгөөд 12 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр Замын-Үүд суманд хоёр удаа албан томилолтоор ажиллаж зөрчлийн хэрэгт 6 холбогдогчийг олж тогтоон хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулсан.
79		5.6.2. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.	-	-	Хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2020	90%	2021	90%	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан орон нутгийн эрхлэх асуудал, чиг үүргийн зохицуулалтад бусад салбар хууль тогтоомжуудыг нийцүүлэх асуудлыг судлаж, ЗГХЭГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу орон нутгийн чиг үүргийг гүйцэтгэхэд хууль тогтоомжуудын зохицуулалтад хэрхэн нийцэж байгаа, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагын талаар “Хөгжлийн шийдэл”, “Гал голомт”, “Мөнгөн соёмбо” зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчид болон иргэдээс саналыг авч, нэгтгэн 13 хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг хүргүүлсэн. Мөн Хог хаягдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон Газрын тосны тухай хуульд нэмэлт,

										<p>өөрчлөлт оруулах тухай хулийн төслүүдэд тусгуулах 10 саналыг хүргүүлсэн.</p> <p>Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувийн хэрэгжилттэй.</p>
80	6.1. Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн экосистем бүхий газар нутгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	6.1.1. Аймгийн Тусгай хамгаалалттай газар нутгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, газар нутгийн хэмжээг 32 хувьд хүргэнэ.	-	-	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ га	2020	31,8	2022	32	<p>Хөвсгөл сумын Хүрэн толгой орчмын 23634.82 га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад, Улаанбадрах сумын "Баянбогд" уулын орчмын 14944.58 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч Ашигт малтмал, Газрын тосны газрын кадастрын мэдээллийн санд бүртгүүлснээр сумын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 1,9 хувиар нэмэгдүүлж нийт нутаг дэвсгэрийн 32,6 хувийг тусгай хамгаалалтад авсан байна. Хатанбулаг суманд түүх соёлын дурсгалт, орон нутгийн хамгаалалттай 12 газрыг тэмдэгжүүлж бүртгэл мэдээллийг 2021 онд сайжруулсан.</p> <p>Нутаг дэвсгэрийн 32.9 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдгээс Аптанширээ сумын "Хайлсан шанд", "Холбоогийн уул", "Баянбуурал", Эрдэнэ сумын "Цант хайрхан", "Хар дэлийн шүү", Хөвсгөл сумын "Уушны говийн өргөтгөл" зэрэг 52290.3 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.</p> <p>Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар тусгагдсан газруудаас 10 газрыг хамгаалалтад авахаар төлөвлөсөн. Улаанбадрах, Мандах, Иххэт, Сайншанд, Даланжаргалан сумдын улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 24 байршил газрыг 22,8 сая төгрөгийн санхүүжилтээр тэмдэгжүүлсэн. Тусгай хамгаалалттай 31 газрын 584037.51 га талбайг эзэнжүүлэх, хамгаалалтыг сайжруулах зорилгоор 55 идэвхтэн байгаль хамгаалагч томилон ажиллуулсан.</p>
81	6.2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой	6.2.1. Хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээх ажлыг	200,0	200,0	Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2020	100 30,00 0мод 390,3 4	2022	100 5 5000	<p>Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн ажлуудыг зохион байгуулж, 3985 айл өрхийн 162333 м2 талбай бүхий нүхэн жорлон, бохирын цооног, 359 аж ахуйн нэгжийн 167940 м2 талбай, 316 орон сууцны 588 орц, нийтийн эзэмшлийн зам талбай, 1080 км авто зогсоол, хүүхдийн тоглоомын талбайд халдваргүйтгэл хийсэн.</p> <p>Айл өрхүүдийг инженерийн шугам сүлжээнд холбож,</p>

	ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулна.	эрчимжүүлж, аж ахуйн эргэлтэд оруулна.			Тарьсан модны тоо, Нөхөн сэргээсэн газрын хэмжээ га,				0 Мод 30	<p>нүхэн жорлонгийн тоог бууруулах бодлогыг хэрэгжүүлж Алтанширээ, Дэлгэрэх Замын-Үүд, Хөвсгөл, Сайншанд, Хатанбулаг, Улаанбадрах сумдад 385 байршил газрыг төвлөрсөн цэвэр, бохир усны шугамд холбож, 61 өрх соруулдаг нойл, 15 өрх эко ариун цэврийн байгууламжтай болж хөрсний бохирдлыг бууруулсан.</p> <p>Хавар, намрын мод тарих аянаар аймгийн хэмжээнд 1933 өрх 9 төрлийн 11544 ширхэг мод, 151 ААНБ 22.1 га талбайд 14 төрлийн 26200 ширхэг мод, нийтийн эзэмшлийн 16.9 га талбайд 7 төрлийн 42846 ширхэг модыг суулгаж нийт 45.5 га талбайд 91186 ширхэг мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр суулгасан модны тоо 3 дахин нэмэгдүүлсэн. 6 сумын нутагт эвдрэлд орж 75,8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж ургамал ургах нөхцөлийг бүрдүүлсэн.</p>
82		6.2.2. Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах арга хэмжээг хэрэгжүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.	18.4	18.4	Ангилж цуглуулсан хаягдлын хэмжээ, зарцуулсан хөрөнгө	2020	22.5 тн, 18.1 сая	2022	150 тн, 18.4 сая	<p>Нийтийн цэвэрлэгээг 45 удаа хийж 6000 га талбайн 1500 тн хаягдлыг цэвэрлэн хогийн цэгт төвлөрүүлж давхардсан тоогоор 1950 аж ахуйн нэгж байгууллага, 12500 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Дэлгэрэх, Мандах, Эрдэнэ, Өргөн сумдууд хог хаягдлын төвлөрсөн цэгийг түрж булшлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Улаанбадрах сум орон нутгийн хөгжлийн сангийн 71.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 0.35 га хог хаягдлын төвлөрсөн цэгийг дарж булшлах, шинээр байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Ахуйн хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх ажилд хог хаягдал түр хадгалах хогийн бункер 280, хог зөөврийн 39 автомашиныг 123 ажилтан ашиглаж сар бүр 6000 тн орчим хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгүүдэд зөөвөрлөн ажилласан.</p> <p>Улсын төсвийн 650,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд, Замын-Үүд сумдын хот тохижилтын газарт 8 автомашин нийлүүлэх ажлыг “Нью ворлд инженеринг энд констракшн” ХХК-гэрээ байгуулан нийлүүлсэн. Хатанбулаг, Хөвсгөл, Замын-Үүд сумдад орон нутгийн хөгжлийн сангийн 242,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 хог зөөврийн үйлчилгээний авто машин тоног төхөөрөмжийг</p>

										<p>нэмэгдүүлснээр 2021 онд улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн 892,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 суманд 13 автомашиныг шийдвэрлэсэн.</p> <p>Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялган ангилах нөлөөллийн арга хэмжээг "Эко говь" төсөлтэй хамтран хэрэгжүүлж, 30 удаагийн нөлөөллийн ажлыг цахим орчинд өрнүүлж, 15000 орчим иргэнд мэдээлэл өгч 40 байршил цэгт хог ялган ангилах зориулалтын сав шинээр байршуулсан. Мөн Сайншанд сумын 8 дугаарт хэрэгжсэн тэгш гудамж төслийн хүрээнд 25 өрх хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын савтай болсон. Аймгийн хэмжээнд 300 орчим иргэд, 60 аж ахуйн нэгж байгууллага хогоо ангилж цуглуулж хуванцар 160 тонн, гялгар нийлэг материал 50 тонн, цаас 20 тонн, лааз 15 тн, шил 11 тонн, төмөр 300тонн, нийт 556 тонн дахивар хаягдлыг Сайншанд Эко говь үйлдвэр болон, Улаанбаатар хотын дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн.</p> <p>Замын-Үүд сумын Сүлд багийн нутаг дэвсгэрт хаягдал хуванцарыг дахин боловсруулах зориулалттай үйлдвэр барих хүсэлт гаргасан иргэнд 300 га газрыг олгосон. Үйлдвэрийн барилгын суурийн ажил хийгдсэн.</p>
83	6.2.3. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг аймгийн хэмжээнд үе шаттайгаар хийж, ашиглалтын зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	50,0	50,0	Ургамал, амьтны тархац нөөцийн Судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна.	2020	Тендер зарлагдсан	2022	100	<p>Амьтны тархац, нөөцийн судалгааны ажлыг Байгаль орчны орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал 44,8 сая төгрөгөөр "Агнуур судлалын нийгэмлэг" ТББ гүйцэтгэсэн.</p> <p>"Борхойн Баян Бүрд" ОНӨААТҮГ-ын мод үржүүлгийн талбайн хүлэмжид говийн ховор ургамлууд болох хармаг, сухай, жигд зэрэг 3 төрлийн ургамлыг 320 м² талбайд үрээр болон мөчрөөр үрслүүлсэн.</p> <p>Мөн ховор бутлаг ургамлын үрийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж хайлаас модны 3 кг, загийн 1 кг үр, сухай модны 500 ширхэг мөчир бэлтгэж үр, суулгацын нөөцийг бүрдүүлсэн. Өргөн сумын цэцэрлэгт хүрээлэнд хармагны модыг тарьж нутагшуулахаар "Монцемент Бюлдинг Материалс" ХХК "Чонон хармаг", "Ямаан хармаг" нийт 3000 ширхэгийг тарьж, усалгаа арчилгааг хариуцан ажиллаж байна.</p>	
84	6.2.4. Байгаль орчны хууль тогтоомжийг	2,0	2,0	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	2020	7, 534	2022	8, 1500	<p>Байгаль орчны салбарын хууль эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр 8 арга хэмжээг төлөвлөж, төлөвлөгөөний дагуу 7 удаагийн сургалт зохион байгуулан 1829 хүнийг хамруулсан.</p>	

		олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог дээшлүүлнэ.								Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 50 удаагийн зөвлөмж, мэдээллийг цахим сүлжээнд байршуулан мэдлэг чадварыг дээшлүүлж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг 90 хувьтай хэрэгжүүлж ажилласан.
85		6.2.5. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.	1,0	1,0	Хүргэсэн мэдээний тоо	2020	3500 0	2021	4000 0	Цаг агаарын аюулт үзэгдэл, гамшгийн үеийн мэдээллийг амжиж анхааруулах системээр дамжуулан мэдээ, мэдээллийг малчдад шуурхай хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/33 дугаар захирамжаар 2,0 сая төгрөг, 2022 онд 3,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, Мобиком, Скайтел компаниудтай гэрээ байгуулан "Масс мессеж" үйлчилгээг үргэлжлүүлэн нийт давхардсан тоогоор 25016 малчин өрхийн 41000 иргэнд хүргэсэн. Ус, цаг уур орчны шинжилгээний төвөөс ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг тухай бүр хүлээн авч сумдын Засаг даргын Тамгын газар болон холбогдох албан тушаалтанд цахимаар шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж иргэд, малчдыг болзошгүй цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгч ажилласан. Мөн Онцгой байдлын газар, Юнитэл ХХК-тай байгуулсан гэрээний дагуу "Масс мессеж" дамжуулахад ашиглагдах дугааруудыг 14 суманд олгосон.
86	6.3. Усны нөөцийн бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат	6.3.1. Усны сан бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэрүүдийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн	-	-	Арга хэмжээний тоо	2020	7	2022	10	Даланжаргалан суманд үйл ажиллагаа явуулдаг "Билэгт баялаг" ХХК, "Ачир" ХХК, "Хас рич" ХХК, "Мөнгөн шонхор" ХХК-ийн эзэмшлийн 4 худаг, Хөвсгөл сумын ус хангамжийн 2 худаг нийт 6 худаг, уст цэгт эрүүл ахуйн бүс тогтоож, хашаажуулан, тэмдэгжүүлэх ажил 2021 онд хийгдсэн. Сайншанд, Замын-Үүд сумдын нийт 19 цэцэрлэг, 8 сургууль, "Чандмань-Илч" ХХК, "Чандмань бадрал" ХХК-ийн ундны усны чанар, аюулгүй байдал, түгээлтэд хяналт

	ундны усаар хангах нэгдсэн менежмен тийг сайжруулн а.	хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолоос сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.								шалгалт хийж, хэрэглээний уснаас 54 сорьц авч, шинжилгээнд хамруулан, заавар зөвлөмж өгсөн. Орон нутгийн төсвийн 3,6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Дэлгэрэх сумыг инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбон усан хангамжид зориулан шинээр 3 худаг гарган эх үүсвэрийг хамгаалан хашаажуулсан.
87		6.3.2. Сумдын ундны усыг чанарын шинжилгээнд хамруулж, цэнгэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, стандартын шаардлага хангасан ундны усаар хангана.	100	ОНТ Сумын төсөв 3 20,0 ОНХС 30,0 ОНТ 2,6 ОНХС 20,0	Шинжилгээнд хамруулсан худгийн тоо, Цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан худгийн тоо Усаар хангагч байгууллагын 20	2020	40 3	2022	53 3	Хүн амыг стандартын шаардлага хангасан ундны усаар хангаж ажлын хүрээнд аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр Дэлгэрэх сумын Хонгорын худагт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан. Сайхандулаан суманд орон нутгийн хөгжлийн сангийн 30,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн худагт ус цэвэршүүлэх систем, цахим төхөөрөмжийг шинэчилж, "Өвсөн гэр" худагт шинээр ус цэвэршүүлэх цахим төхөөрөмжийг тус тус байршуулсан. Хөвсгөл суманд орон нутгийн төсвийн 2,6 сая төгрөгийн хөрөнгөөр ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг шинэчилсэн. Эрдэнэ сумын төвийн ундны усны нэгдсэн төв усан санг усаар хангагч байгууллагын 20,0 сая төгрөгийн хөрөнгөөр хашаажуулах камержуулах ажлыг зохион байгуулж эрүүл ахуйн бүсийн дэглэмийг шинэчлэн тогтоосон. Улаанбадрах сумын төвийн "Болор ус-2" худагт орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая төгрөгийн хөрөнгөөр ус цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулж, 69,0 сая төгрөгийн хөрөнгөөр 2 худгийг "Ухаалаг ус түгээх" байр болгохоор ажил гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Сайншанд суманд "Чандмань илч" ОНӨХХК-ийн 8.5 сая төгрөгийн хөрөнгөөр "60 гэр байр" ус түгээх байрыг цахимжуулан, иргэдийг 24 цагийн турш тасралтгүй усаар хангагдах боломжийг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд орон нутгийн төсөв болон, усаар хангагч байгууллагын нийт 3681,1 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр ус цэвэршүүлэх 3 төхөөрөмж суурилуулж, 2 төхөөрөмжийг засварлан, ухаалаг ус түгээх 1 байрыг ашиглалтад оруулсан.

88		6.3.3. Умард говийн гүвээт-Халхын дундад тал, Галба-Өөш-Долоодын говийн сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, усны аюулгүй байдлыг сайжруулна.	-	-	Усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	2020	90	2022	100	<p>Газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг "Усны мэдээллийн өнө мөнхийн ундарга төв" ХХК 42,6 сая төгрөгийн өртөгтэйгөөр гэрээ байгуулан гүйцэтгэсэн.</p> <p>Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж ус түгээх 50 байрны орчны хог хаягдлыг цэвэрлэсэн.</p> <p>Орон нутгийн төсвийн 3,6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Дэлгэрэх сумыг инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбон усан хангамжид зориулан шинээр 3 худаг гарган эх үүсвэрийг хамгаалан хашаажууллаа. 2022-2025 он хүртэл аймгийн хүн амын ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн байдал, хамгаалалт, шугам сүлжээ, түгээлтийг сайжруулах, эрүүл аюулгүй усаар хангах зорилгоор усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулсан.</p> <p>Дэлгэрэх, Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг, Иххэт, Улаанбадрах сумдын 14 худагт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулсан, Өргөн, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдын 10 худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хашааг засуулж шаардлагад нийцүүлсэн. Мөн Даланжаргалан суманд үйл ажиллагаа явуулдаг "Билэгт баялаг" ХХК, "Ачир" ХХК-ийн эзэмшлийн 2, Хөвсгөл сумын ус хангамжийн 2, нийт 4 худгийн цэгт эрүүл ахуйн бүс тогтоож, 3 худаг шинээр гаргаж хашаажуулан, тэмдэгжүүлсэн.</p> <p>Сум бүр хүн амын усан хангамжийн эх үүсвэрүүдийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэхэд анхаарч 40 худаг, Сайншанд, Замын-Үүд сумдын нийт 19 цэцэрлэг, 8 сургууль, "Чандмань-Илч" ХХК, "Чандмань бадрал" ХХК-ийн ундны усны чанар, аюулгүй байдал, түгээлтэд хяналт шалгалт хийж, хэрэглээний уснаас 54 сорьц дээж авч шинжилгээнд хамруулан, заавар зөвлөмж өгсөн.</p> <p>6 суманд 7 булгийн эхийг хашиж хамгаалан, 1 булгийн хашааж засаж тохижуулсан. Орон нутгийн төсөв болон, усаар хангагч байгууллагын нийт 3681,1 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр ус цэвэршүүлэх 3 төхөөрөмж суурилуулж, 2 төхөөрөмжийг засварлан, ухаалаг ус түгээх 1 байрыг</p>

										ашиглалтад оруулан усан хангамжийг нэмэгдүүлэх, баталгаат усаар хангах ажлыг хийж гүйцэтгэсэн.
89		6.3.4. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг дахин ашиглах боломжийг судалж хэрэгжүүлнэ.	АХБ 3,6 сая ам доллар		Гүйцэтгэлийн хувь	2020	0	2022	100	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн МОН3388/3713 төсөл”-ийн хүрээнд хоногт 3000м3 бохир ус хүлээн авах хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлыг улсын төсвийн 6350.8 сая төгрөгийн төсөвт өртөгөөр “Компорт импекс” ХХК гүйцэтгэж, 2022 оны 07 дугаар сард байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус цэвэрлэх байгууламж нь механик, биологи, гүйцэд цэвэрлэгээний технологитой ба цэвэрлэгдсэн усыг цэцэрлэг, зүлэгжүүлэлт, зам талбай, хөрсний усалгаанд ашиглахад зориулагдсан цооногтой, цэвэрлэгээний явцад гарсан лагийг боловсруулан бордоо, түлш гаргах тоног төхөөрөмжтэй жишиг байгууламж болсон.
90	7.1. Орон нутгийн батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, нийгмийн аюулгүй байдлыг хангана.	7.1.1. Зэвсэгт хүчний жанжин штабаас өгөгдсөн хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хамруулах хяналтын тооны хувийг нэмэгдүүлнэ.	1.3	3.3	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	2020	100%	2022	100%	Аймгийн Засаг даргын 2021 оны А/465 дугаар захирамжаар томилогдсон Цэрэг татлагын товчоо нь аймгийн Биеийн тамир спортын газарт тус оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг коронавируст халдвараас урьдчилан сэргийлж халдваргүйжүүлэлтийн дэглэмийг горимын дагуу чанд сахиулан зохион байгуулж явууллаа. “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийг тодорхойлох журам”-ын дагуу аймгийн Цэрэг татлагын товчооны эмч нар, Эрүүл мэндийн газрын холбогдох албан тушаалтнууд, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар, багийн Засаг дарга нартай сургалт зохион байгуулан, I, II ээлжийн цэрэг халах, татах ажлыг тогтоосон хугацаанд зохион байгуулан Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги салбараас тогтоосон хяналтын тоог 100 хувь биелүүлсэн. Цэргийн жинхэнэ алба хаах 18-25 насны иргэдийн тоо 18,8 хувиар нэмэгдсэн.
91		7.1.2. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны	3,2	3,2	Төлөвлөсөн бүрэлдэхүүний хамрагдалтын хувь	2021	92%	2022	100%	Аймгийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу 14 сумдад суман, салааны бэлтгэл үүрэгтэн, ангийн буу, автотехникийг тус тус 100% томилгоожуулсан. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутгийн хамгаалалтын материаллаг баазыг бэхжүүлэх

		төлөвлөлтийг шинэчилнэ.								<p>зорилгоор 174,6 сая төгрөгийн санхүүжилтийг төсөвлөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулсан.</p> <p>Зэвсэгт хүчний 336 дугаар анги үүсэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг тохиолдуулан 144,3 сая төгрөгийн, Зэвсэгт хүчний 090, 253, 281-р тусгай салбаруудад нийт 60,0 сая төгрөг, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд 24,4 сая төгрөг, нууцын горимыг бүрдүүлэн ажиллахад 3.3 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.</p>
92	7.2. Хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хилийн торон саадыг шинэчлэх, хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	7.2.1. Хилийн ангиудыг орчин үеийн техник хэрэгслээр хангах, хилийн торон саадыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ.	240,0	248,1	Хил хамаалалтад туслах хүчний зөвлөлийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 100%	2020	100%	2022	100%	<p>Аймгийн Засаг даргын 2021 оны А/48 дугаар захирамжаар "Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл"-ийн 2021 оны төлөвлөгөөг батлан, Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнийг 2021 онд Хилийн 0168 дугаар ангийн байрлалд зохион байгуулсан.</p> <p>Хилийн 0129 дүгээр ангийн Таван толгой хилийн харуулын байрыг шинээр барих, 10 кВт-ын ЦДАШ татах, хилийн 0168 дугаар ангийн мөр хянах зурвас татах, гүний худаг гаргах, ус цэвэршүүлэгч тавих, хилийн 0108 дугаар ангийн 10 айлын орон сууцны барилгын их засварын ажилд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас тус бүр 80,0 сая төгрөг нийт 240,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Хилийн инженерийн байгууламж, өргөст утсан хашааг сэргээн засварлах, эргэлтийн цэг тэмдэгжүүлэхэд нь аймгийн Засаг даргын захирамжаар 4.3 сая, Хөвсгөл, Хатанбулаг сумдын Засаг даргын захирамжаар хилийн 0168 дугаар ангид тус тус 1.9 сая, хилийн 0108 дугаар ангид хяналт удирдлагын төвд хяналтын дэлгэц шинээр худалдан авахад зориулж Замын-Үүд сумын Засаг даргын захирамжаар 4,0 сая төгрөг, нийт 10.2 сая төгрөг, нийт төсвөөс 250,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн, төлөвлөгөөг 86.0 хувьтай хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Хил хамгаалах зөвлөлийн 2022 оны зөвлөгөөнийг 12 сард зохион байгуулна.</p>
93		7.2.2. Хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.	10,0	48,1	Дэмжлэг үзүүлэхэд зарцуулсан мөнгөн дүнгийн	2020	18,5	2022	45,0	<p>Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хилчдийн сэтгэл санаа, дархлааг дэмжих зорилгоор анги тус бүр 1,0 сая төгрөг, хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодисыг аймгийн Онцгой комиссоос шийдвэрлэж, хугацаат цэргийн 100 албан хаагчдад 1,5 сая төгрөгийн өртөг бүхий дархлаа дэмжих</p>

					ХЭМЖЭЭ					<p>багцыг өгсөн.</p> <p>Хилийн салбарт гэр бүлийн хамт үр бүтээлтэй ажиллаж буй хилчдэд тус бүр 300,0 мян төгрөгийн дэмжлэг үзүүлж, талархал хадгалуулан, хил хамгаалалтад туслах хүчний гишүүн 6 малчин иргэнд тус бүр 50,0 мянган төгрөг, “Хүндэтгэл өргөмжлөл”-өөр шагнасан.</p> <p>Хилийн цэргийн 0108 дугаар ангийн алба хаагчдын 28 айлын орон сууцны барилгын засвар, Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн алба хаагчдын орон сууцны гадна, дотор сантехникийн засвар, Хилийн цэргийн 0168 дугаар ангийн 0137 дугаар салбарын хариуцсан хэсгийг бүхэлд нь өндөр хүчин чадал бүхий камерын хамгаалалтад шилжүүлж “Цахим салбар” болгоход зориулж аймгийн Засаг даргын захирамжаар анги тус бүрт 50,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p>
94	7.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүл	7.3.1. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, бэлэн байдлыг хангаж, гамшгийн эрсдэлийг бууруулна.	30,0	-	Гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээ хийлгэсэн сумын тоо	2020	3	2022	4	<p>Гамшгийн эрсдэлийг бууруулах эрсдэлийн үнэлгээг 2021 онд Дэлгэрэх, Эрдэнэ, Хөвсгөл, сумдад хийсэн. Гал түймэр унтраах, аврах тусгай зориулалтын 1.1 сая төгрөгийн үнэ бүхий автомашин, аймгийн Засаг даргын шийдвэрээр шуурхай албаны автомашины бэлтгэл, бэлэн байдлыг хангах үүднээс 3.7 сая төгрөгийн дэмжлэг, Пургон авто машин, хөдөлгөөнт хяналтын цэг (чиргүүл)-ийг дотоод нөөц бололцоонд тулгуурлан 5,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх зэрэг дэмжлэгийг үзүүлсэн.</p> <p>Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл 2 удаа хуралдаж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах эрсдэлийн үнэлгээг үе шаттайгаар хийх төлөвлөгөө боловсруулсан. ТӨБЗГ-ын 2021 оны 336 дугаар тогтоолоор Алтанширээ, Хөвсгөл, Хатанбулаг сумдад гал унтраах зориулалттай 2 төрлийн тээврийн хэрэгсэл, төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.</p> <p>Гамшиг, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг зохион байгуулан 860 зөрчлийг илрүүлж, 183 зөрчлийг газар дээр нь арилгуулж бусад 677 зөрчлийг арилгуулахаар Улсын хяналтын байцаагчийн танилцуулга-12, заавал биелүүлэх албан шаардлага-171, мэдэгдэл-15 хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт зөрчсөн 47 иргэн, 9 аж ахуйн нэгжийг, Зөрчлийн тухай</p>

	НЭ.									<p>хуулийн 5.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг үндэслэн нийт 17,9 сая төгрөгийн шийтгэл оногдуулсан.</p> <p>Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 178 иргэн, аж ахуй нэгж байгууллагад олгож орон нутгийн төсөвт 5,7 сая төгрөгийг төвлөрүүлсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/58 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургуулийг Сайхандулаан, Хатанбулаг сумдад, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Мандах Хөвсгөл сумдад зохион байгуулан, гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг үзлэгийн хүрээнд сумдын Онцгой комисс, Засаг даргын Тамгын газар, аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулан олон нийтийн оролцоонд суурилсан гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, тухайн орон нутгийн эрсдэл, эмзэг байдалд суурилан орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, нийт 1432 ажилтан алба хаагч, иргэнийг хамруулсан.</p> <p>Мөн Сайншанд сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг чадавжуулах сургалтыг 11 дүгээр сард зохион байгуулж “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Мэргэжлийн ангийн дүрэм”, “Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал”, “Эмнэлгийн анхны тусламж” сэдвүүдээр 130 гаруй ажилтан, алба хаагчийн гамшгаас хамгаалах мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн.</p> <p>“Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийг 2022-2025 он хүртэл 3 жилийн хугацаатай Дорноговь аймгийн Иххэт, Хатанбулаг, Сайншанд сумдад хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажилласан.</p>
95		7.3.2. Гамшгийн эрсдэлд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын бэлэн байдлыг хангаж, оролцоог	3,0	3,0	Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо	2020	14/13	2021	14/13	<p>“Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”, “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль”-ийг 3 дугаар сард, Коронавируст халдвар /ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д заасан түвшинтэй нийцүүлж 14 сумын мэргэжлийн ангийн 3254 албан хаагчдад зохион байгуулан ажилласан. Нэгдсэн арга</p>

		нэмэгдүүлнэ.							<p>хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын 4 сургуулийн нийт 240 ажилтан, албан хаагч, 2161 сурагч, 7 цэцэрлэгийн 423 багш, ажилчид, эцэг, эх, 636 хүүхэд, багачуудад “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх” сэдвээр 88 цагийн танхимын дадлага сургалтыг зохион байгуулав.</p> <p>Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуульд 14 сумын 96 аж ахуйн нэгж, байгууллагын 7332 иргэн хамрагдсан. Улаан Загалмайн дунд шатны хорооны дэмжлэгтэйгээр ОБГ-ын сургалтын танхимд 6 сая гаруй төгрөгийн иж бүрэн засвар, үйлчилгээг хийж гамшгаас хамгаалах арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>. Гамшигт тэсвэртэй орон нутаг төслийн хүрээнд Эрдэнэ, Дэлгэрэх, Хөвсгөл сумдын сургагч багш нар “Бэлэн бай” багцаар нийт 600 орчим иргэнд сургалт зохион байгуулсан. Зорилтот сумдад гал унтраах анхан шатны багаж, гал унтраагуур зэрэг 5.2сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан, багийн Засаг дарга нарт “Үер, уснаас үрсээ хамгаалья” аяны удирдамж, төлөвлөгөөний талаар танилцуулан хэрэгжилтийг хангаж ажиллах, гамшиг, осол цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх талаар малчид, иргэдэд өгөх зөвлөмж бүхий 9 төрлийн 700 гаруй боршур, тараах материалыг хүлээлгэн өгсөн.</p>
96	7.4. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	7.4.1. Дэвшилтэт технологиын камержуулалтын нэгдсэн системийг нэмэгдүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулна.	10,0	12,4	Нэмэгдүүлсэн болон засаж сэргээсэн камерийн тоо, Зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ	2020	16 камер 3,9 сая төгрөг	2021	<p>Орон нутгийн хөгжлийн сангийн нийт 139,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Айраг, Алтанширээ, Өргөн, Улаанбадрах, Эрдэнэ, Сайншанд сумдад камержуулалтын болон засварын ажлыг хийснээс олон нийтийн газруудыг 30.7 сая төгрөгийн зардлаар 5 цэгт 16 камер нэмж байрлуулан, дүрс бичлэгийн техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг баримтлан цагдаагийн газрын теле хяналтын нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулсан.</p> <p>Аймаг, орон нутгийн хөгжлийн сангийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй цэгүүдийг камерын нэгдсэн хяналтад бүрэн оруулснаас гадна бусад сумдаас 120,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар камержуулалт, 350,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэрэлтүүлэг шинээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж иргэд, оршин суугчдын</p>

										амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлснээр ажлын хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.
97		7.4.2. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргаж, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.	30,0	30,0	Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувь, Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2020	100%	2021	100%	<p>Гэр бүл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор "Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх нь" сэдэвт бичил төслийн уралдааныг зарлаж, 11 төслөөс 5 төслийг шалгаруулан, тус бүр 2,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.</p> <p>Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд болон "Саран хөхөө" театртэй хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Хайр нэмье, Хүчирхийллийг хасъя" нөлөөллийн аяны хүрээнд 8 төрлийн видео шторк, 18 постер мэдээлэл, 3 подкаст хийж, Facebook Boost хэлбэрийг ашиглан 560,0 мянган төгрөг зарцуулж цахим орчинд түгээснээр нийт 188935 хүнд хүрч, 1032 хүн бусадтай хуваалцаж, 934 хүнд таалагдаж, 1100 хүн нүүр зургаа сольж аянд нэгдсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 435 өрхийн мэдээллийн сан үүсгэн, эрсдэл өндөртэй 36 өрхийн 164 иргэн, үүнээс 78 хүүхдэд 2 удаагийн 5378,0 мянган төгрөгийн хүнс, тэжээл, амин дэм, түлээ нүүрсний дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Сайншанд, Замын-Үүд сумдын түр хамгаалах байранд 52 хүүхэд, 9 насанд хүрсэн иргэн, нийт 61 иргэнийг хүлээн авч хууль, эрх зүйн зөвлөгөө, өмгөөлөл, эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйн үйлчилгээг тогтмол хүргэж, гэр бүлд нь эргэн нэгтгэсэн. Иргэдийг дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж сард 2-3 удаа эргүүл хяналт хийж, гэр бүлийн орчинд нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа" хамтарсан багийн үндэсний V чуулганд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга болон сумдын Засаг дарга бөгөөд хамтарсан багийн ахлагч нар оролцсон бөгөөд Алтанширээ сумын Засаг дарга гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021, 2022 онд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний "Сайн туршлага" сэдвээр танилцуулга мэдээлэл хийж, үндэсний түвшинд түгээн дэлгэрүүлсэн.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг,</p>

										зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу гэр бүл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэж, бичил төслийн уралдаануудыг хэрэгжүүлэн ажилласнаар зорилтот бүлгийн 3200 гаруй иргэдэд эрх зүйн мэдлэг олгосноос гадна төслийн хүрээнд Даланжаргалан сум, хамтарсан багаас санаачлан түр хамгаалах байрыг шинээр тохижуулан хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.
98		7.4.3. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэн, замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлж, зам тээврийн ослыг бууруулна.	20,0	20,0	Төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувь, Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2020	100% 4	2021	100% 4	<p>Аймгийн Засаг даргын 2021 оны А/77 дугаар захирамжаар "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран "Хяналтын камерын систем, замын хөдөлгөөний аюулгүй байдал" сэдэвт сургалтыг 2021 оны 01 дүгээр сард зохион байгуулж, 12 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зам тээврийн ослыг бууруулах зорилгоор Цагдаагийн газар, Авто тээврийн төв, Татварын хэлтэс, Сайншанд сумын ИТХ, ЗДТГ-тай хамтран "Бүсээ зүүцгээ", "Татвараа төлцгөө", "Үзлэгтээ хамрагдацгаая" уриан дор 2021 оны 05 дугаар сараас 06 дугаар хооронд зохион байгуулан, нийт 4 аудио, 3 шторк, 1 постер бэлтгэн цахим орчинд түгээж, 10956 хүнд хүргэсэн. Аяны хугацаанд нийт 7116 тээврийн хэрэгсэл авто тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулсан.</p> <p>Замын сангийн 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар энэ онд Сайншанд сумын 4 газарт авто зам, 3 цэгт авто зогсоол шинээр барих, шинэ автозамуудад 7 ширхэг хурд сааруулагч, 64 ширхэг замын тэмдэг тэмдэглэлээ, Говьсүмбэр-Замын-Үүд чиглэлийн хатуу хүчилттай авто замын холбогдох 10 цэгт 30,0 сая төгрөгийн санхүүжилтээр нойр сэргээгч дэржгэнүүр байршуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Зам тээврийн гэмт хэрэг, зөрчилд хүүхдүүд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 21,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Ногоон гэрэл, цагаан шугам",</p>

										“Замын хөдөлгөөний цагаан толгой” зэрэг тэмцээн, уралдааныг зохион байгуулж, давхардсан тоогоор 2100 гаруй сурагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн мэдлэг олгосон.
99		7.4.4. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх олон талт арга хэмжээг эрчимжүүлнэ.	20,0	31,3	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн өсөлтийн хувь, Зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ	2020	4 Аймгийн нийт хүн амын 30% 25,6	2022	4 Аймгийн нийт хүн амын 50% 31,3	<p>Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу эрх зүйн боловсролыг иргэдэд хэрхэн хүргэвэл үр өгөөжтэй байх талаар иргэдийн дунд цахим санал асуулгад 235 иргэнийг хамруулж, санал асуулгын дагуу эрх зүйн мэдлэг олгох үг, эшлэл, хуулийн заалтын хамт постер байдлаар бэлтгэн цахим орчинд түгээсэн.</p> <p>Өсвөр үе, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор богино хэмжээний бичлэгийн уралдааныг зохион байгуулж, нийт 20 бичлэг ирүүлснээс 5 бичлэгийг шилдгээр шалгаруулж, 92,0 мянга гаруй иргэдийн хандалт авч бүтээлээр дамжуулан урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг уриалсан.</p> <p>Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажлыг соёл урлагаар дамжуулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор аймгийн Саран хөхөө театрт 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж “Гэрэл асаа” ёс зүйн драмын жүжгийн уран бүтээл туурвисан бөгөөд 12-р сард үзэгч болон аймгийн нийт хүүхдүүдэд хүргэхээр ажиллаж байна.</p> <p>Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилд үүрэн холбооны аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлж, 2.0 сая төгрөг зарцуулан, Skytel, Mobicom үүрэн холбооны операторын нийт 300 хэрэглэгчийн гар утасны дуудлага үйлчилгээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, дуудлага, мэдээллийг хүлээн авах 102, 107, 108 утсыг сурталчлан, нөлөөллийн мэдээллийг масс мессеж үйлчилгээгээр үнэ төлбөргүйгээр орон нутгийн нийт хэрэглэгчдэд хүргэсэн.</p> <p>Салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд 63 удаагийн цахим сургалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 36,5 мянга гаруй иргэдийг хамруулж, түрүү оны мөн үетэй харьцуулахад 4.6 хувиар өсч, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, төлөвлөсөн ажлаа 90.0 хувьтай</p>

										хэрэгжүүлсэн.
100	7.5. Хууль сахиулах салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.	7.5.1. Салбарын барилга байгууламжийг шинээр барих, засвар шинэчлэлт хийх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	60,0	137,4	Дэмжлэг үзүүлэхэд зарцуулсан мөнгөн дүнгийн хэмжээ	2020	700,3	2022	60,0	Аймгийн Засаг даргын 2021 оны А/232 дугаар захирамжаар Цагдаагийн газарт гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр алсын дуудлагад үүрэг гүйцэтгэх туулах чадвар сайтай /LAND-76/ маркийн тээврийн хэрэгслийг 60,0 сая төгрөг, Тагнуулын Ерөнхий газрын Замын-Үүд дэх газарт автомашин худалдан авахад нь 50,0 сая төгрөг, Айраг сумын Цагдаагийн тасагт 15,0 сая төгрөгөөр суудлын автомашин, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Улсын бүртгэлийн хэлтэст иж бүрэн компьютер, техник хэрэгслийн дэмжлэгт нийт 15.0 сая төгрөг, Цагдаагийн газрын телекамерын хяналтын төвд байрлах Сайншанд сумыг холбосон 35 камерыг засварлах ажилд 9,6 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж, алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлэхэд 137,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.
101		7.5.2. Төрийн архивыг стандартын шаардлагад нийцсэн зориулалтын байртай болгож, үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөл, аюулгүй байдлыг хангана.	20,0	24,1	Барилгын ажлын гүйцэтгэл Техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт	2020	Нийт 2 төрлийн 4 ширхэг	2022	1 100	Төрийн архивын баримтын хадгалалтыг стандартын шаардлагад нийцүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/473, А/486 дугаар захирамжаар 24,1 сая төгрөг шийдвэрлүүлж, зориулалтын нягтруулсан шүүгээ, автомат чийгшүүлэгч зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдсан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/561 дүгээр захирамжийн хүрээнд 19.2 сая төгрөгийн санхүүжилтээр Төрийн архивын мэдээллийн технологийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилж, архивын мэдээллийн сангийн аюулгүй ажиллагааг 100% хангасан. Төрийн архивын стандартын шаардлагад нийцсэн байр барих асуудлын судалгаа мэдээллийг гаргасан.

НАЙМ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Зорилго 8. Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, ногоон үйлдвэрлэлийг дэмжсэн, эдийн засгийн өрсөлдөх чадвартай орон нутгийг хөгжүүлнэ.

102		8.1.1. Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	0	0	Арга хэмжээний тоо	2020	0	2021	2	<p>Зүүнбаян-Ханги чиглэлийн 226 км шинэ төмөр замын төсөлд төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашиг малтмал ашиглах зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2022 оны А/204, А/369, А/624 тоот захирамжаар нийт 232 байршилд тус тус олгосон.</p> <p>Төмөр замын угсралтын ажил бүрэн дуусч улсад хүлээлгэн нээлтийн үйл ажиллагааг 11 сард зохион байгуулж, импорт, экспортын бараа бүтээгдэхүүний нэвтрэх хүчин чадал 20 сая тонноор, төмөр замаар тээвэрлэж байгаа нийт тээврийн хэмжээ 65 хувиар нэмэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүнээ илүү дөт, бага зардлаар дэлхийн зах зээлд хүргэх боломжийг бүрдүүлсэн..</p>
103	8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.	8.1.2. Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.	Хятад Ард Улсын Засгийн газрын 201 сая юань (75 тэрбум төгрөг)-ийн буцалтгүй тусламж		Гүйцэтгэл-ийн хувь	2020	30	2021	70	<p>Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 223 дугаар тогтоолын дагуу “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлсэн. “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд шилжүүлсэнтэй холбогдуулан Хил, Гааль, Мэргэжлийн хяналт, Гадаадын иргэн харьяатын алба зэрэг төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн албууд үйл ажиллагаа явуулах бөгөөд гүний гарцаар зорчигч, ачаа, тээврийн хэрэгсэл нэвтрэх эхлэнэ. Мөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлал, бизнесийн чиглэлүүд түлхүү хөгжин, экспортын бүтээгдэхүүн гурав дахин нэмэгдэх чухал ач холбогдолтой.</p> <p>Замын-Үүд боомтыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтын ажил үргэлжилж байна. Уг бүтээн байгуулалтаар зорчигч тээврийн 30, ачаа тээврийн 28 барилга, дэд бүтэц, ногоон байгууламж баригдан, шуурхай удирдлагын төвтэй холбогдсон орчин үеийн теле хяналтын систем бүхий тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх ухаалаг гарцууд болон өндөр хүчин чадлын рентген, тоног төхөөрөмжүүд суурилагдана.</p> <p>Боомтыг шинэчлэх, өргөтгөх бүтээн байгуулалт хийгдсэнээр нийт талбай 8 дахин, өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4 дахин, том оврын ачаа тээврийн хэрэгслийн тоо 3 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 7 дахин нэмэгдэж зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.</p>

104		8.1.3. Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг технологи нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	0	0	Ухаалаг технологи нэвтрүүлсэн тээврийн хэрэгслийн тоо	2020	0	2021	0	<p>Сайншанд сум доторх нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж буй 3 автобусанд GPS, түлш хэмжигч суурилуулах ажлыг "Гайхам" ХХК-иар гүйцэтгэж 3.2 сая төгрөгийг зарцуулан хүлээн авсан. Сайншанд сум дотор нийтийн тээврийн үйлчилгээг Дэнжийн малчны байр-3-р сургууль, Өндөр дов-Жанчивын хороолол гэсэн маршрутаар явуулж 3801 том хүн, 6773 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн. Сайншанд сумын 6-р багийн нутагт 640 хүүхдийн сургууль ашиглалтад орохтой холбогдуулан тухайн чиглэлд шинээр маршрут баталж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.</p> <p>Замын-Үүд сумын Засаг даргын шийдвэрээр өвлийн улирал эхэлж байгаатай холбогдуулан 10 дугаар сарын 01-ний өдрөөс алслагдсан багийн нутаг дэвсгэрээс сумын төвд сургууль, цэцэрлэгт хамрагддаг хүүхдүүдийг тээвэрлэх зориулалтаар 25 хүний суудалтай автобусыг өглөө 07:00-08:10 цагийн хооронд явуулж эхэлсэн.</p>
105	8.2. Орон нутгийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	8.2.1. Аймгийн аялал жуулчлалын төлөвлөгөөг хэрэгжүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	15,0	15,0	Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, жуулчдын тоо	2020	Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөтэй болсон. - хэрэгжилтийн хувь-10	2021		<p>Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бэлтгэх зорилгоор “Зочлох, үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв” ТББ, “Монголын зочлох үйлчилгээний гэр холбоо” ТББ-уудтай хамтран “Ковидын дараах борлуулалтын хэв маяг” сэдэвт цахим сургалтад Сайншанд, Замын-Үүд сумдад үйл ажиллагаа явуулж буй зочид буудлын төлөөлөл 16 аж ахуйн нэгж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан “Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх” цахим сургалтад 5 аж ахуйн нэгж байгууллагыг тус тус хамруулсан.</p> <p>Жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд аялал жуулчлалын танилцуулгыг 1000 ширхэг хэвлүүлэн тарааж, “Манай нутгаар аялаарай” контент арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p> <p>Хилэнцэт хөшөөг тохижуулах ажлыг эхлүүлж 1100м2 талбай бүхий 20 машины авто зогсоол, 2 га талбайг хашаажуулан 4 төрлийн 1000 ширхэг мод тарьж, жуулчдын аялах орчныг сайжруулсан. DTV, Саран хөхөө театртэй хамтран “Амттай аялал” нэртэй 3 цуврал нэвтрүүлгийг бэлтгэн телевиз болон цахимаар үзэгчдэд хүргэж, 7000 гаруй үзэгч үзэж сонирхсон.</p> <p>Коронавирусын улмаас 2021 онд Хамарын хийд, Хан</p>

										Баянзүрх хайрхан чиглэлийн шашин мөргөлийн аялал багасан дотоодын 21000 орчим аялагч хүлээн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад аялагчдын тоо 65,6%-аар буурсан бол 2022 онд гадаадын 718, дотоодын 90630, нийт 91348 жуулчин аялаж, аялагчдын тоо урьд оноос 4 дахин нэмэгдсэн.
106		8.2.2. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг шинэлэг байдлаар сурталчилна.	0	0	Цахим хандалтын тоо	2020	40,00 0	2021		<p>“Манай нутгаар аялаарай” контент арга хэмжээг feel Mongolia цахим сайт болон бусад цахим хаягаар тус тус олон нийтэд хүргэж 20000 гаруй мянган цахим хандалт авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахим хандалт 5 хувиар нэмэгдсэн.</p> <p>Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд “Хамарын хийдийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ, “Далт мөнгөн шанд” ХХК, Хамарын хийдийн гэр буудал, жуулчны бааз, гар урлалын 15 төлөөлөл оролцож орон нутаг, онцлог бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчилсан ба үзэсгэлэнг зорин ирсэн зочид төлөөлөгчдөд 2700 ширхэг танилцуулга, гарын авлага хүргэж, Улаанбаатар хотын аялал, жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч 10 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан.</p> <p>Аймгийн ДТВ, Саран хөхөө театртай хамтран “Амттай аялал” 3 цуврал нэвтрүүлгийг бэлтгэн 7000 гаруй хандалт авсан. Мөн МҮОНП-оор Дорноговь аймгийн Түүх соёлын хосгүй үзмэрийн талаар 2 удаагийн ярилцлагыг бэлтгэн аймаг орон нутгийн онцлогийг сурталчилсан.</p>
107		8.2.3. Үндэсний зан заншил, уламжлал, түүх соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	-	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2020	5	2022	6	<p>Үндэсний зан заншил, уламжлал, түүх соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор цахим сургалтыг 2, үзэсгэлэн худалдааг 1 удаа буюу нийт 3 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 14 аж ахуйн нэгж, 1207 иргэнийг хамруулсан. Мөн түүх соёлын дурсгалт нэр бүхий 9 газрыг судалгаагаар тогтоож аялал жуулчлалыг хөгжүүлэх сурталчлах нэгдсэн цахим санд байршуулсан.</p> <p>Музей сургалт, судалгааны төвийн дэргэд аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд уртын дууны дугуйланг хичээллүүлж байна. Соёлын яамнаас зохион байгуулсан “Музейн бүтээлч үйлдвэрлэл” цахим сургалтад 5 хүнийг хамруулсан.</p>

										Морин аялал, шагайн наадгай, соёлын биет бус өвийн талаар иргэд олон нийтэд зориулсан танилцуулга, мэдээлэл, контент зэргийг бэлтгэн, цахимаар иргэдэд сурталчлан ажилласан.
108	8.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.	8.3.1. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих замаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	-	-	Үзүүлсэн дэмжлэгийн тоо, нэмэгдсэн ажлын байрны тоо	2020	16, 13	2022	10, 6	<p>Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах чиглэлээр тус онд СХС-аас 7 иргэн, аж ахуйн нэгжид 85.0 сая, Засгийн газраас арилжааны банкаар дамжуулан хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд 14 иргэн, аж ахуйн нэгжид 8,9 тэрбум төгрөгийн зээл олгогдож 24 ажлын байрыг бий болгож дэмжлэг үзүүлсэн. Эрдэнэ, Мандах, Хатанбулаг, Сайхандулаан сумдын “Сум хөгжүүлэх сан”-гаас сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх 2 иргэнд 12,0 сая, хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх 2 иргэнд 40,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Засгийн газраас арилжааны банкаар дамжуулан хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд нийт 213 иргэн 3,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг хөдөө аж ахуй, түүхий эд бэлтгэх чиглэлээр авсан.</p> <p>Сайншанд сумын 1 иргэн Жижиг, дунд үйлдвэрийн газраас 15,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч арьс, шир боловсруулах цехийн үйл ажиллагааг шинээр эхлүүлсэн.</p>
109	8.3.2. Бэлчээрийн төлөв байдал, даацад тулгуурлан нөхөн сэргээх, хөдөөгийн усан хангамжийг нэмэгдүүлэн бэлчээр ашиглалтыг сайжруулна.	ОНТ, Бусад		Шинээр гарсан, сэргээн засварласан худгийн тоо	2020	54	2022	15	<p>Айраг, Алтанширээ, Хөвсгөл, Эрдэнэ, Замын-Үүд сумдын СОНХС-ийн 204,2 сая төгрөгийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 8 худгийг “Грандхолдинг” ХХК, “Эхний эхэн” ХХК-ууд шинээр гаргаж ашиглалтад оруулсан.</p> <p>Айраг, Иххэт, Өргөн, Мандах, Хатанбулаг сумд ОНХС-ийн 7 сая төгрөгийн хөрөнгөөр 20 гар худгийг малчдын оролцоотойгоор шинээр болон сэргээн засварласан.</p> <p>Дээрх 28 худгийг шинээр болон сэргээн засварласнаар 32 мянган га бэлчээрийг усжуулж 40.2 мянган толгой малыг услах боломж нөхцөл бүрдсэн.</p>	
110	8.3.3. Малын чанар, ашиг	ОНТ, ХХО		Шинээр нэмэгдүүлсэн	2020	78 00	2022	35 0,	Биотехнологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн зохиомол хээлтүүлгийг орон нутагт зохион байгуулах ажлын	

		шимийг сайжруулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлнэ.			өндөр ашиг шимт мал, шинээр тархаан сайжруулсан хээлтүүлэгч малын тоо толгой		5 43		25 0	<p>хүрээнд Алатау, Хар тарлан үүлдрийн 257 толгой үхэр, 2382 нутгийн монгол хонь, дэлгэрэхийн улаан омгийн ямааны нийт 2639 толгой малд шингэлсэн үр болон гардан хээлтүүлэг хийж нутгийн малын ашиг шимийг сайжруулсан.</p> <p>Алтанширээ, Сайншанд сумд “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас мал чанаржуулах, махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх, эрчимжсэн аж ахуйн эрхлэх 2 иргэн, аж ахуйн нэгжид 113,0 сая, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас “Цагаан сүүний буян” ХХК, “Өлзийт баян мод” ХХК-д 360,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.</p> <p>Өндөр ашиг шимт малын тоо 78376 толгойд хүрч, 5 төрөл дээрээ 0,5%-иар өссөн нь нийт мал сүргийн 2,9 хувийг эзэлж байна.</p>
111		8.3.4. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулж, экспортыг нэмэгдүүлнэ.	24,9	24,9	Гэрчилгээний тоо, шинжилгээнд хамрагдсан малын тоо, зарцуулсан зардал	2020	1737 3 2409 6 19,2 сая төгрөг	2022	1742 8 4669 0 19.9 сая төгрөг	<p>Сайншанд сумын Зүүнбаян баг, Эрдэнэ суманд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж шинээр байгуулагдсан. 14 суманд 33 малын их эмч, 3 бага эмч ажиллаж, боловсон хүчний хангалт 47,1%-тай байна. Мах 3736.6 тн, гулууз 8494 ширхэг, арьс шир 127,467 ширхэг, ноос, ноолуур 1478.3 тн, сүү 3401 л, гадагш чиглэлтэй 91849 толгой малд гэрчилгээ бичигдэж, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд хяналт тавьж баталгаажуулан ажилласан.</p> <p>Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/564 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж Сайншанд, Замын-Үүд сумдын махны 9, сүүний 3, нийт 12 цэгт хяналт шалгалт хийж, махны 18 дээж, сүүний 7 нийт 25 дээжийг шинжилгээнд хамруулсан. Шинжилгээгээр антибиотикийн үлдэгдэлтэй дээж илрээгүй.</p> <p>Хяналт шалгалтад хамрагдсан 12 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл, 28 малчинд 2 төрлийн гарын авлага өгч, мэдээллээр ханган, нийт 1.2 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Төлөвлөгөөт шинжилгээний дагуу ямын шинжилгээнд 7050 адуу, бруцеллёзын шинжилгээнд 41934, сүүний цагирган урвалын шинжилгээ 2150, үхрийн сүрьеэ 5215, асколын урвалын шинжилгээ 3800 толгой мал, нян судлалын шинжилгээнд 132 ш эмгэгт материал ирсэнээс цусан халдварт 3, галзуу 3, колибактериоз 2, ДХХ 7, шүлхий 60,</p>

										<p>маеди весна 1, аденоматоз 1, адууны нийлүүлэг 3, эктопаразит 2, стафилококк 2 тус тус лабораторийн шинжилгээнд оношлогдож, хорио цээр, хязгаарлалтын арга хэмжээг тогтоон хариу арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Шүлхий, Үхрийн лейкоз, сүрьеэ, Бруцеллёз, Бог малын мялзан өвчний тандалтыг зохион байгуулж, 16705 толгой малыг хамруулан нийт 19.9 сая төгрөгийг зарцуулан малын халдварт өвчнөөс сэргийлэх, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг ханган хяналт тавьж ажилласан.</p>
112		8.3.5. Атрын IV аяныг хэрэгжүүлж, орон нутгийн онцлогт тохирсон газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг тогтвортой өсгөнө.	364.3	697.5	Нэмэгдсэн талбайн хэмжээ /мкв, га/	2020	9909, 64	2022	200, 2	<p>Газар тариалангийн чиглэлээр 217 өрх, 23 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулан, иргэн, аж ахуйн нэгжүүд нь төмс 25,838 га, хүнсний ногоо 63,263 га, малын тэжээл 33,90 га, жимс, жимсгэнэ 15,20 га, нийт 138 га талбай, бага оврын трактор 72, үрлэгч 5, ухагч 3, 37 га-ын дуслын усалгааны систем, 900 м2 өвлийн хүлэмж 2ш, 10520 м2 зуны хүлэмж 65 ширхэг, 950 тоннын багтаамж бүхий 22 зоорийг үйл ажиллагаандаа ашигласан.</p> <p>Тариалангийн талбайн хэмжээ 29%, зоорийн хангамж 10,5%, техникийн хангамж-21,6%, хамгаалагдсан хөрсний тариалалт 579 м2-аар нэмэгдсэн.</p>
113		8.3.6. Мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	ОНТ, Бусад		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2020	2	2022	2	<p>Мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг малчдад шуурхай хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар жил бүр 2,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж "Мобиком"ХХК, "Скайтел"ХХК-тай тус тус гэрээ байгуулан "Масс мессеж" үйлчилгээг нэвтрүүлсэн. Тайлант хугацаанд цаг уурын болон цаг үеийн мэдээллийг давхардсан тоогоор нийт 105404 иргэд, малчдад хүргэсэн.</p> <p>Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 100 тн тэжээл бэлтгэхээс 250 тн өвс, 61.5 тн тэжээл, сумдын нөөцөд 1400 тн өвс, 420 тн тэжээл бэлтгэхээс 853.6 тн өвс, 123,3 тн тэжээл бэлтгэсэн. Малчдын түвшинд 7037 тн өвс, 639 тн үйлдвэрийн тэжээл, 382 тн гар тэжээл, 226 тн хужир шүү бэлтгэн өвс тэжээлийн нөөцийг 63,8 хувьтай бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажил 81,8 хувьтай хангагдсан.</p>

114		8.3.7. Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин хөгжүүлж, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.	-	-	Хяналт шалгалтад хамрагдсан ААН, иргэдийн тоо Тохирлын үнэлгээнд хамруулсан худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, бүтээгдэхүүний тоо	2020	51 412	2022	70, 450	<p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны 01/05, 01/48 дугаар удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хүнсний үйлдвэрлэл 3, хүнсний худалдааны 112, түгээлтийн 2, хадгалалтын 2, тээвэрлэлтийн 1, нийтийн хоолны 36, хүргэлтийн хоолны 1, нийт 160 объектыг хамруулан улсын байцаагчийн 6 акт, 2 дүгнэлт, 23 албан шаардлага, 38 зөвлөмжийг өгч, илэрсэн зөрчил дутагдалд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч газар дээр нь арилгах арга хэмжээ авч ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд 303 худалдаа, 231 үйлдвэр, 142 үйлчилгээ эрхлэгч үйл ажиллагаа явуулдаг. Тайлант хугацаанд 14 сумын нийт 248 худалдаа, үйлчилгээ, 28 үйлдвэрийг тохирлын үнэлгээнд хамруулан заавар, зөвлөгөө өгч, стандартуудыг тухай бүрд тайлбарлан таниулж, 34 бүтээгдэхүүн, 242 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон. Тохирлын үнэлгээнд хамрагдсан худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний стандартын шаардлага хангалт 60%-тай байна.</p>
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ -89,4										